MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,141.925... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.10. Лхагва. №093 (4707) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

"МИМИ"-Г ХИЛЭЭР ОРУУЛЖ ИРВЭЛ ЗӨРЧИЛ ГЭЖ ТООЦНО

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ИРГЭД ҮҮРГЭЭ МЭДДЭГ Ч, ХААНА ХАНДАХАА МЭДЭХГҮЙ ГЭВ

V нүүрт

Дугаарын 60 мөр

## Хуулийн цоорхойгоор мөнгө угаахаа боль

Н.БАТЗАЯА

Их хотод суурьшихаар ирсэн нэгэн өөрийн гэсэн алга дарам газартай болно гэдэг амаргүй даваа. Газрын сугалаанд оролцоно,бүтэхгүй бол хэн нэгний гарыг цайлгах гэж оролдоно, хэдэн сар хүлээнэ, уурлана, бухимдана. Эцэс сүүлд нь хэн нэгэн айлын хашаанд аль эсвэл үерийн далан, суваг зэрэг хориотой газар гэрээ барьж, суурьшдаг. Амьдрах алга дарам газраа олж авах гэж махаа идэж буй нэгэн байхад олон нийтийн эзэмшлийн талбайд сэмхэн гэгч хашаа татаж аваад орсон, гарсан автомашины жолоочоос 1000 төгрөг хураах хүн ч олон болж. Үүнийг жижигхэн путик, зам талбайг хориглох улаан, цагаан өнгийн хаалттай зогсоолууд гэрч-лээд өгөх биз. Хэтрүүлээд хэлэхэд, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллага бүрийн гадна талбайд хашаа хатгаад орсон гарсан автомашины жолооч нараас мөнгө авах хүмүүс олширчээ.

Үргэлжлэл нь III нүүрт

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль ДЭЛХИЙН СОНОРТ БАЙНА



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Б.ДАВААХҮҮ

Бид ирэх сарын 26-нд Ерөнхийлөгчөө сонгоно. Өнгөрсөн долоо хоногт УИХ-д суудалтай улс төрийн гурван хүчин нэр дэвшигчээ тодруулж, АН-аас УИХ-ын гишүүн асан Х.Баттулга, МАН-аас УИХ-ын дарга М.Энхболд, МАХН-аас Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр нарын эрхмүүд нэр дэвшихээр болсон. Тэгвэл Ерөнхийлөгчийн сонгууль хийгээд Монгол Улсын талаар дэлхийн хэвлэлд ойрын өдрүүдэд хэрхэн мэдээлснийг "Монгол дэлхийн хэвлэлд" булангаараа хүргэж байна.

Үргэлжлэл нь III нүүрт



Forbes MONGOLIA
MONGOLIAN PROPERTY AWARDS
ЗАЛУУСЫН ХОТХОН
X Apartment
ШИЛДГЭЭР ТОДОРЛОО



Дэлхийн 15 оронд хэвлэгдэн гардаг, санхүүгийн №1 Forbes сэтгүүлээс жил бүр шалгаруулдаг **"MONGOLIAN PROPERTY AWARDS"**-ын 2016 оны Үл хөдлөхийн шилдгээр **Залуусын хотхон "X Apartment"** тодорч **"Шилдэг орон сууц"** өргөмжлөлийг хүртэн, дэлхийн орон бүрт тодруулдаг энэхүү нэр хүндтэй шагналын эзэн боллоо.

Залуусын хотхон **"X APARTMENT"** нь хотын төвөөс 4км зайд, нийслэлийн А зэрэглэлийн бүсэд байрлалтай бөгөөд **Япон архитекторын орон зайн төгс шийдлээр**, өрөө бүрт нарны гэрэл бүрэн тусахаар маш нарийн тооцсон зохион байгуулалтын өвөрмөц төлөвлөлт, 24 цагийн хүлээн авах ресепшн, Монтессори сургалттай цэцэрлэг, таны хэрэгцээг бүрэн хангах бүх төрлийн үйлчилгээг нэг дор бүрдүүлсэнээрээ бусдаас онцлог давуу талтай юм.



Стандарт загвар: 1 өрөө
30 - 32 мкв



Стандарт загвар: 2 өрөө
54 - 64мкв



Стандарт загвар: 3 өрөө
59.5 - 82 мкв



Дуплекс загвар: 2-4 өрөө
37.5 - 104 мкв

ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ ЯПОН БРЭНДҮҮДЭЭР "X APARTMENT"-ЫГ ТОНОГЛОЛОО

VEKA — ГЕРМАН ВАКУМ ЦОНХ
TOTO — ЯПОН САНГИЙН ТОНОГЛОЛ
LG Hausys — СОЛОНГОС ОБОЙ
NIPPON PAINT — ЯПОН БУДАГ, ЭМУЛЬС
EGGER — АВСТРИ ПАРКЕТАН ШАЛ
ThyssenKrupp — ГЕРМАН ЦАХИЛГААН ШАТ
AQUATHERM — ГЕРМАН ХОЛБОХ ХЭРЭГСЭЛ
MEGAWOOD — MEGAWOOD ХААЛГА

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд "УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ" ХХК

77009919, 96066329, 88002312, 88030203

www.xapartment.mn

| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2410.00 | 2420.00 | ФУНТ | 3081.00 | 3169.00 |
| ЕВРО | 2604.00 | 2666.00 | РУБЛЬ | 40.50 | 42.50 |
| ИЕН | 21.19 | 21.46 | ЮАНЬ | 347.50 | 350.50 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2407.00 | 2419.00 | ФУНТ | 3081.00 | 3156.00 |
| ЕВРО | 2600.00 | 2666.00 | РУБЛЬ | 40.28 | 43.23 |
| ИЕН | 21.01 | 21.56 | ЮАНЬ | 347.50 | 350.40 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

## “МИМИ”-Г ХИЛЭЭР ОРУУЛЖ ИРВЭЛ ЗӨРЧИЛ ГЭЖ ТООЦНО



Б.ТОГТОХ

Төрийн ордонд өчигдөр хоёр байнгын хороо хуралдлаа. Тодруулбал, Хуульзүйн байнгын хорооны хуралдаан өглөө 09.50 цагт эхэлж, УИХ-аар хэлэлцэж буй дөрвөн хуулийн төслийн эцсийн болон анхны хэлэлцүүлгийг хийсэн юм. Харин Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо Төрийн ордны Их жанжин Д.Сүхбаатарын танхимд хуралдаж, өнгөрөгч долоо хоногт чуулганаар анхны хэлэлцүүлгийг хийсэн Хог хаягдлын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн юм.

Гэр бүлийн хүчирхийллийг эхний удаад зөрчилд тооцох нь Хуульзүйн байнгын хорооны эхний хэлэлцсэн асуудал бол Эрүүгийн хууль нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Ажлын хэсгийн танилцуулгыг УИХ-ын гишүүн Х.Нямбаатар хийж, чуулган болон байнгын хороогоор хэлэлцэх явцад гишүүдийн гаргасан санал нэг бүрийг хэлэлцэн тусгасан гэдгийг онцоллоо. Мөнгө угаах, терроризм, хээл хахууль өгөх, байгаль орчныг бохирдуулах, улсын эдийн засгийн аюулгүй байдал, өмчийн эсрэг гэх мэт тодорхой тооны хууль зөрчсөн үйлдлийг аль нэг хуулийн этгээдийн эзэмшигч, хөрөнгө оруулагчдын шийдвэрээр гүйцэтгэх захирал нь хэрэгжүүлсэн нь нотлогдвол тухайн захиралд л хариуцлага тооцдог. Үүний цаана үүрэг, чиглэл өгсөн хуулийн этгээдийн удирдлагууд, эзэмшигчид хариуцлага хүлээлгүй үлддэг байдлыг өөрчлөх нь зүйтэй гэдэг чиглэлийг барьж, хуулийн төслийг боловсруулсан аж. 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 80 гаруй зүйл, заалтаар хуулийн этгээдэд ял шийтгэл оногдуулах зохицуулалттай байгаа бол хэлэлцэж буй төслөөр энэ тоог бууруулж 30 орчим зүйл, заалтын хүрээнд хуулийн этгээдэд ял шийтгэл оногдуулахаар өөрчилсөн байна. Гишүүд асуулт асууж хариулт авсны дараа зарчмын зөрүүтэй санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэнээр чуулганы хуралдаанд шилжүүлэв. Байнгын хорооны хуралдааны дараагийн хэлэлцсэн хуулийн төсөл бол олны анхаарлын төвд буй Зөрчлийн тухай хуулийн төсөл юм. Ажлын хэсгийг танилцуулгыг мөн л Х.Нямбаатар гишүүн хийлээ. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүгийн үеэр мөн л гишүүдийн зүгээс санал гарч байсан юм. Тухайлбал, УИХ-ын гишүүн О.Батнасан хүнс импортлох болон экспортлоход хуульд тавигдсан шаардлагыг зөрчсөн тохиолдолд өнөөдрийн хуулиар хувь хүнийг 1-10 сая төгрөгөөр торгодог бол энэ төсөлд 10-100 сая төгрөгөөр торгохоор тусгасан байна. Энэ асуудлыг эргэж харахыг зөвлөв. Мөн Б.Ундармаа гишүүн аж ахуйн нэгжид ногдуулж буй 100 сая төгрөгийн торгуулийг бууруулах нь зөв гэсэн юм. Мөн өдрийн хуралдаан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээр үргэлжиллээ. УИХ-ын гишүүн Х.Нямбаатар “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдон Эрүүгийн хууль хөндөгдөж байна. Засгийн газар Зөрчлийн тухай хуулийн төслийг өнгөрсөн оны арванхоёрдугаар сард өргөн мэдүүлсэн юм. Харин Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь 2017 оны нэгдүгээр сард батлагдан, хоёрдугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа. Уг хуулийн дагуу гэр бүлийн хүрээнд үйлдэж буй хууль зөрчсөн үйлдлийг эхний удаад зөрчил, давтан үйлдсэн тохиолдолд эрүүгийн хэрэг хэмээн тооцох юм. Энэ зохицуулалттай нийцүүлэн Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн” хэмээн тайлбар хийлээ. Мөн дээрх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж буй хүрээнд УИХ-ын гишүүн Н.Амарзаяа, Л.Энхболд нар “эмийн түүхий эд” хэмээх нэр томъёог хуульд тусгах, ингэснээр эмийн найрлагад ордог “мими” хэмээх түүхий эдийг хууль бусаар хилээр оруулсан үйлдлийг зөрчил хэмээн тооцох санал гаргасан болохыг хуралдаанд оролцогчдод танилцууллаа. Уг нэмэлт өөрчлөлтийг анхны хэлэлцүүлгээр батлах санал гишүүдийн дэмжлэг хүлээсэн юм. Хуралдааны төгсгөлд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийснээр хуралдааныг өндөрлөв.

### Хог хаягдлын хууль эцсийн хэлэлцүүлгээ давав

УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны өчигдрийн хуралдаан гишүүдийн 52.6 хувийн ирцтэйгээр хуралдсан юм. Хурлаар нэгхэн хуулийн төслийг хэлэлцсэн. Тодруулбал, өнгөрөгч долоо хоногийн чуулганы хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг хийсэн Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийв. Засгийн газраас 2016 оны арванхоёрдугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2017 оны тавдугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн. Мөн чуулганы нэгдсэн хуралдаанаар олонхийн дэмжлэгийг авсан саналуудыг уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэмж тусгасан байна. Тухайлбал, төслийн хоёрдугаар бүлэгт тухайн салбарын үйл ажиллагааны мэргэжлийн онцлогтой холбоотойгоор хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх журам боловсруулах, хог хаягдлын норматив хэмжээг тогтоох, мэдээллийн сан бүрдүүлэх, үнэ тарифыг тогтоох, санхүүжүүлэх, заавар, аргачлал батлах эрхийг төрийн захиргааны зарим байгууллагад тусгайлан зааж өгсөн болон, бусад хууль тогтоомжтой нийцүүлсэн өөрчлөлтүүдийг хийжээ. Мөн хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулах этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбоотой зохицуулалтыг Газрын тухай хуультай нийцүүлэн нэгтгэж нэг заалт болгон төслийн зургадугаар бүлэгт нэмжээ. Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулж асуулт асууж, санал хэлэх гишүүн байсангүй. Иймд уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулах саналыг хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь дэмжлээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Газар өмчлөлийн асуудлаар нээлттэй сонсгол хийв



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

УИХ-ын гишүүн Л.Болдын санаачилсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Гэр хорооллын хөгжлийн тухай хоёр хуулийн төслийг энэ хаврын чуулганаар хэлэлцэх аж. Үүнтэй холбоотойгоор өчигдөр Төрийн ордны нээлттэй сонсголын танхимд “Газар өмчлөл ба гэр хорооллын хөгжил” хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Барилга хот байгуулалтын яам, НИТХ, Дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, Газрын зохион байгуулал, геодези зурагзүйн газар, Нийслэлийн Газрын алба, Гэр хорооллын дэд бүтцийн газар, Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Их дээд сургуулиудын багш, эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөлөл оролцлоо. Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын гишүүн Л.Болд “Энэхүү хуулийн төслийн гол зорилт нь иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах, хот, суурин газрын инженерийн дэд бүтцээр хангагдаагүй нутаг дэвсгэрт иргэдийн өмчилсөн газрыг тохижуулан хөгжүүлэх, амьдрах орчноо сайжруулах талаар гаргасан иргэдийн санаачилгыг дэмжих, үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэлээ. УИХ-ын гишүүн Л.Болд гишүүний санаачилсан Гэр хорооллын хөгжлийн тухай хуулийн төсөл нь зургаан бүлэгтэй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар олон эерэг үр дүн бий болно гэж үзэж байгаа аж. Тухайлбал, Иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах, эдийн засгийн эргэлтэд иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийг оруулж амьжиргааны чанарыг дээшлүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ бөгөөд хөрсний бохирдол буурах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай болон хот төлөвлөлтийн бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтэд нааштай нөлөө үзүүлж, гэр хорооллын хөгжлийн шинэ давалгааг эхлүүлнэ хэмээн хууль санаачлагч тайлбарласан юм.

## Хар тамхины эсрэг гурван улс хамтарч тэмцэнэ гэв

УИХ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт энэ сарын 8-12-ны өдрүүдэд БНХАУ-д ажлын айлчлал хийж байна. Айлчлалын хүрээнд Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хооронд 2017-2021 онд хамтран ажиллах үйл ажиллагааны хөтөлбөрт гарын үсэг зурсан юм.

Мөн Монгол, Хятад, Орос гурван улсын хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар санал солилцсон байна. С.Бямбацогт сайд БНХАУ-д хийж буй ажлын айлчлалынхаа хүрээнд БНХАУ-ын Хятадын Коммунист Намын Төв хорооны гишүүн, Хууль зүйн хорооны нарийн бичгийн дарга Мэн Жианжүтэй уулзлаа. Уулзалтын үеэр сайд С.Бямбацогт дипломат харилцааны 68 жилийн түүхтэй Монгол Хятад хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг төдийгүй хууль сахиулах салбарт эрчимтэй хөгжиж байгааг тэмдэглэсэн байна. Энэ үеэр талууд иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн хоёр талын хамтын ажиллагаанд хоёр орны хууль зүй, дотоод хэргийн салбар ихээхэн чухал үүрэгтэй болохыг онцлоод зургаан жилийн дараа Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын хийж байгаа айлчлал өндөр үр дүнтэй болно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв. Мөн Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагаа улам өргөжиж байгаа энэ цаг үед гурван улсын хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, тухайлбал хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах, мөнгө угаах гэмт хэрэгтэй хамтран тэмцэх механизм бий болгох нь зүйтэй гэдэг дээр санал нэгдсэн байна.

ШАР МЭДЭЭ

## Экс гишүүн Л.Эрдэнэчимэг мөөг тариад завгүй явна





2012-2016 онуудад УИХ-ын гишүүний зөөлөн сэнтийд заларч байсан улстөрчдийн үнэмлэхүй олонхи нь суудлаасаа буусан. Тэр тусмаа АН-аар овоглож байсан олон туршлагатай гишүүд сонгуульд бүдэрч, эдүгээ чөлөөт гишүүн болчихоод буй юм. Ялагдлын шокноосоо гарч чадаагүйгээс болсон уу, юутай ч 2016 оны сонгуулиас хойш тэд сураг тасарсан гэхэд болно. Тухайлбал, УИХ-ын гишүүн Р.Бурмаа, Л.Эрдэнэчимэг, А.Бакей нарын сураг тасарсан гишүүд өнгөрөгч долоо хоногт намынхаа хурлын үеэр уулзацгааж харагдлаа. Тэр тусмаа өнгөрсөн парламентад тун ч амь нэгтэй байсан АН-ын эмэгтэй улстөрчид удтал тэврэлдэн уулзацгааж харагдсан юм.

Тухайлбал, намын Их хурлын үеэр Архи, тамхины эсрэг хууль санаачилсан атлаа өөрөө Төрийн ордонд тамхи татаж, архи ууж суусан бичлэг нь олонд цацагдаж, 2016 оны сонгуулиар санамсаргүй ялагдал хүлээсэн Л.Эрдэнэчимэг гишүүн тун ч өнгө зүс засчихсан давхиж явлаа. Хэсэг хугацааны турш ажин түжин байсан экс гишүүн маань тэгвэл мөөг тарих сургалтад хамрагдаж, хүлэмжинд цагаан мөөг тариалан, бизнес хийж суугаа бололтой. Тэрбээр, энэ талаараа “Мөөг тарих сургалтандаа суучихлаа. Үйлдвэрийн барилгаа эхлүүлчихлээ. Удахгүй та нарыгаа монгол хөрсөнд ургасан цагаан мөөгөөр дайлна аа” хэмээн өөрийн зургаа оруулжээ. Экс гишүүн олон төрлийн бизнестэй. Эмийн худалдааны салбарт тэргүүлдэг “Монос” компани түүнийх гэдгийг хүн бүхэн мэднэ. Нөгөө талаар цэцгийн худалдаа эрхэлж, Төрийн ордонд цэцгийн хүлэмж байгуулах шахдаг байлаа. Гишүүдийн төрсөн өдөрт амьд цэцгээр бэлэг барьж, өөрийн сонгогдсон дүүргээ цэцгээр бялууртал чимэглэдэг эрхэм гишүүн шинэ төрлийн бизнесээ эхлүүлжээ. Тун удахгүй экс гишүүнийхээ тарьсан цагаан мөөгөөр хоол хийж идэх нь ээ, монголчууд.

# ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

## Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль ДЭЛХИЙН СОНОРТ БАЙНА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

### **reuters.com:** Сөрөг хүчин жүдогийн од тамирчнаас бизнесийн магнат болсон Х.Баттулгыг нэр дэвшүүллээ

Эдийн засгийн хямралтай нүүр тулсан далайд гарцгүй Монгол Улсад ирэх сард Ерөнхийлөгчийн сонгууль болно. Энэ сонгуульд сөрөг хүчин болох Ардчилсан намаас жүдо бөхийн од тамирчин асан, бизнесмэн Халтмаагийн Баттулга нэр дэвшихээр болжээ.

Гуравхан сая хүн амтай, Чингис хааны төрсөн нутаг гэдгээр нь сайн мэдэх тус улс БНХАУ, ОХУ гэсэн хоёр хүчирхэг гүрний дунд хавчуулагдан он удаан жил ардчиллын замаар замнасан байдаг. 1990 оны хувьсгалаар Монголын улс төрд эргэлт гарч, үүний үр дүнд ашигт малтмалын арвин их нөөц баялаг нь гадаадын хөрөнгө оруулагчдын харааг булаах болсон. Монголчууд зургадугаар сарын 26-нд дараагийн Ерөнхийлөгчөө сонгоно. Одоогийн Ерөнхийлөгч, Ардчилсан намын нөхөр Цахиагийн Элбэгдорж уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хөөсрөлтөөс эдийн засгийн хүндхэн цаг мөчид хоёр дахь удаагийн бүрэн эрхийнхээ хугацааг дуусгаж байна. Өнгөрсөн жилийн парламентын сонгуульд МАН үнэмлэхүй ялалт байгуулан парламентын 76 суудлын 65-ыг нь авсан бол өмнөх 2012-2016 оны эвслийн Засгийн газрыг АН тэргүүлж байлаа. Харин жүдо бөхийн од тамирчнаас бизнесийн магнат болсон Х.Баттулга өнгөрсөн жилийн сонгуульд ялагдахаасаа өмнө тус парламентын гишүүн байв.

Тэрбээр Зам тээвэр, хөдөө аж ахуйн сайдаар ажиллаж байсан бөгөөд БНХАУ-ыг шүүмжлэгч гэдгээрээ зартай нэгэн. Түүний хувьд Монгол Улс хөршөөсөө эдийн засгийн хувьд хэт хараат болох вий гэдэгт санаа зовнидог байна. Х.Баттулга МАН-аас нэр дэвшигч УИХ-ын дарга М.Энхболдтой өрсөлдөнө.

### **Xinhuanet.cn:** Монголын гол гурван нам нэр дэвшигчээ сонголоо

БНХАУ-ын төрийн мэдлийн “Синьхуа” мэдээллийн агентлаг “Монголын гол гурван улс төрийн хүчнээс нэр дэвшигчийг тодорлоо” гэсэн гарчиг бүхий мэдээг нийтлэжээ.


AKIpress
16:59 09-05-2017
MAIN AKIpress CA-News
KAZAKHSTAN KYRGYZSTAN MONGOLIA TAJIKISTAN TURKMENISTAN
POLITICS BUSINESS INCIDENTS SOCIETY CULTURE SPORT
CENTRAL ASIA > POLITICS

**Mongolian Democratic Party chooses candidate to run for president**

13:39, 05 May 2017, 926

Twitter Facebook Print

**AKIPRESS.COM** - The Mongolian Democratic Party held an all-member poll nationwide on 3rd of May, which resulted in Kh.Battulga being elected as the party's presidential candidate, reports news.mn.

The poll was conducted from 10 am. to 8 pm., engaging all the party's supporters in 21 provinces, 330 soums and 9 districts and 152 khoroos of the capital.

Kh.Battulga led the poll with 2740.94 marks, R.Amarjargal ranked second with 2374.85 points, D.Dorligjav third with 1058.64, N.Altankhuyag fourth with 1044.20, L.Bold fifth with 917.30 and B.Jargalsaikhan sixth with 213.66 points.

Mongolia will choose its fifth president on June. There are three political parties eligible to nominate a

Үүнд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д суудалтай гурван намын нэр дэвшигч өрсөлдөх учиртай. Тэгвэл Ардчилсан намын VIII их хурлаар энэ удаагийн сонгуульд УИХ-ын гишүүн асан Халтмаагийн Баттулгыг нэр дэвшүүлэхээр болжээ.

МАН-аас одоогийн намын дарга, УИХ-ын дарга М.Энхболд, харин МАХН Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг тус тус нэр дэвшүүлэхээр болсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд зургадугаар сарын 26-нд болно. Холбогдох хуулийн дагуу энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д суудалтай намын нэр дэвшигч л өрсөлдөх эрхтэй бөгөөд МАН парламентад 65 суудалтай бол Ардчилсан нам ес, МАХН нэг суудалтай билээ. Тэд Сонгуулийн Ерөнхий хороонд тогтсон хугацаанд бүртгүүлэх бөгөөд СЕХ-оос нэр дэвшигчдийн үнэмлэхийг гардуулан батламжилдаг. Үндсэн хуульд заасны дагуу парламентын гишүүн, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байдаг юм.

### **akipress.com:** ОУВС–гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах хамгийн том саадаа арилгалаа

Монголын эрх баригчид гадны хөрөнгө оруулагчид дотоодын банкаар мөнгөн гүйлгээгээ хийнэ гэсэн шийдвэрээ цуцалснаар ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах хамгийн том саадаа арилгасан тухай “Монцамэ” агентлаг мэдээлжээ. ОУВС-гийн захирлуудын зөвлөл Монголд 5.5 тэрбум ам.долларын багц бүхий тусламж үзүүлэх эсэхээ дөрөвдүгээр сарын 28-ны уулзалтаар шийдвэрлэх ёстой байсан. Гэвч, Монголын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийн тулд Рио Тинто Оюу толгойн бүтээгдэхүүний орлогоо орон нутгийн банкаар дамжуулах шаардлагатай болсноос үүдэн шийдвэр гаргахаа түр азнажээ. Гадаадын өр төлбөр нь тэнгэрт тулсан, төгрөгийн ханш суларсан тус улсын хамгийн том гадаад худалдааны түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт буурч байгаа нь эдийн засагт нь давхар дарамт болж байгаа юм. Төсвийн байнгын хорооны гишүүн Ч.Хүрэлбаатар ОУВС-гийн хөтөлбөрийг хойшлуулах цаг бидэнд байхгүй гэж мягмар гарагийн хурлын үеэр хэлсэн тухай УИХ-ын албан ёсны цахим хуудаст нийтлэгдсэн байна. Шинжээчдийн хэлж буйгаар Оюутолгой төслийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулагдах 5.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээг Монгол дотоодын банкаар дамжуулах сонирхолтой байсан гэнэ. Монголын Засгийн газар 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, тус төслийн 34 хувийг эзэмших болсон. Үүний зэрэгцээ хоёр жилийн өмнө дахин гэрээ байгуулж, гүний уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдсэн байдаг.

### **baikalfinans.com:** ОХУ–д бэлэглэсэн “Дайны замаар” хөшөөг нээлээ

Тавдугаар сарын 09-ний баярыг тохиолдуулан Монголын ард түмнээс бэлэглэсэн “Дайны замаар” хөшөөний нээлт Москва хотын Хүндэтгэлийн дэнж дэх Ялалтын цэцэрлэгт хүрээлэнд болжээ. Их буу чирч буй морьдын уг баримлыг Монголоос тус улсад бэлэглэж буй тухай орон нутгийн сайт мэдээлсэн байна.

Морьдын баримлыг 2015 оны тавдугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинд танилцуулж байсан бөгөөд монголчуудын санаачилгаар энэхүү баримлыг урлан бэлэглэж буй аж. Хөшөөг уран баримлач А.Очирболд урласан байна.

“Энэ хөшөө Эх орны дайны аугаа ялалтын үед бидэнд Монголын ард түмний зүгээс үзүүлсэн тусламж дэмжлэгийн илэрхийлэл юм” гэдгийг Москвагийн Думын дарга А.В.Шапошников нээлтийн үйл ажиллагааны үеэр онцолжээ. Хөшөөний нээлтийн ёслолд Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил мөн оролцсон байна. Тэрбээр “Зөвлөлт холбоот улсын ард түмэн дэлхий нийтийг фашизмын аюулаас сая сая охид залуусынхаа амиар дэнчин тавьж аварсан. Тэдний баатарлаг үйлсийн ачаар дэлхий фашизмаас аврагдан, бид өнөөдөр аз жаргалтай амьдарч байна” хэмээлээ.

Дугаарын 60 мөр

## Хуулийн цоорхойгоор мөнгө угаахаа боль

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Тэр дундаа үйлчилгээний байгууллагын гадаа хашаа хатгаад мөнгө хураах нь ихэсчээ. Тухайлбал, “UB mart их дэлгүүр”, “Мобиком” корпораци, 100 айлын дөрвөн замын уулзварт байрлах “ABB” центр, Улсын Драмын Эрдмийн Театр, Спортын төв ордон болон Залуучуудын ордны гадна талбай гээд дурьдаад байвал олон газар байна. Тэр бүү хэл, нийслэлийн Хангарьд ордны гадаах нийтийн эзэмшлийн зам талбайд төлбөртэй зогсоол байх юм. Эдгээр зогсоолууд 30 минут нь 500, нэг цаг нь 1000 төгрөгийн үнэтэй. Энд бяцхан тооцоо хийж үзье. Нэг зогсоолд өдөрт дунджаар 50 хүн нэг цаг машинаа байршуулахад 50 мянган төгрөг. Харин энэхүү мөнгө нэг сард 1.5 сая, нэг жилд 18 сая төгрөг болно. Зөвхөн нэг зогсоолд машинаа байршуулсан 50 хүний мөнгийг жилээр тооцож гаргахад ийм байна. Төлбөртэй зогсоолд машинаа байршуулж байгаа иргэдийн тоо 50-аар тогтохгүй. Үүнээс ч их бий. Энэ их мөнгө хэнд очиж, юунд зарцуулагдаж байна вэ гэдэг хэнд ч тодорхой биш. Тухайн байгууллагын орлого болдог уу, зам ашигласны төлбөрт явж байна уу гэдэг эргэлзээтэй. Аль ч талаас нь харсан хэрэглэгчийн эрх ашгийг зөрчсөн мэт. Байгууллага хураасан мөнгөө шууд авдаг гэвэл хэтэрхий шударга бус. Учир нь тухайн байгууллагаар үйлчлүүлж байгаа юм чинь машинаа зогсоолд нь үнэ төлбөргүй тавимаар. Нөгөө талаас зам ашигласны төлбөрт хурааж авдаг гэвэл улс иргэдээ хуулийн цоорхойг ашиглаж завшсан хэрэг болох биз. Тодруулбал, жил бүр жолооч нар автозам ашигласны төлбөрт 20 мянган төгрөг тушаадаг. Ийм байтал зам ашигласны төлбөрийг давхар төлнө гэдэг мөн л шударга бус. Нийслэлийн төв хэсэгт машины зогсоол хомсыг далимдуулан зарим нэг нь бизнес хийх ухаанаа ийн олсон бололтой. Хүссэн байгууллага болгон хашаа хатгаад ард иргэдээсээ 1000 төгрөгийн хураамж аваад байх юм уу. Үүнийг хянадаг, шалгадаг байгууллага гэж байна уу. Өмнө нь төлбөргүй байсан байгууллагын машины зогсоол нэг өглөө босоход л мөнгө авдаг болсон байх нь энүүхэнд. Хоёр, гурван үйлчилгээний байгууллага нэг хашаанд байрлана. Дээрээс нь төлбөртэй зогсоол ажиллуулна. Төлбөрийн мөнгийг хэн нь авдаг нь ч тодорхой бус. Зогсоолгүй газар зогсоол гаргасан нэрийдлээр иргэдээс мөнгө угаасаар байх уу. Үүнд хяналт, шалгалт хэрэгтэй. Тэгэхгүй бол захын нэг ТҮЦ хүртэл тойруулж хашаа бариад мөнгө хураах нь байна.

## Оффшорчидтой яагаад хариуцлага тооцохгүй байна вэ

Д.ГАНБОЛД

Монголчууд дэлхийн баячуудын ашигладаг оффшор данс гээч зүйлтэй тун саяхнаас танилцаж эхлэв. Хэрэвзээ Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн холбоonoос “Панама Паперс” буюу олон улсад оффшор данс эзэмшдэг 500 гаруй хүний нэрийг ил болгож, тэр дунд нь Монголын нэртэй зүстэй улстөрчид багтаагүйсэн бол мэдэх ч үгүй өнгөрч мэдэх байлаа. Учир нь эгэл жирийн иргэдэд харь нутагт хадгалуулах хэмжээний мөнгө байхгүй шүү дээ. Тиймээс оффшор гэх харь үгийг тайлбарлахаас энэхүү нийтлэлээ эхлэх нь зүйтэй болов уу. Оффшор гэж хилийн гадна гэсэн утгатай үг агаад татварын болон нууцлалын таатай дэглэм бүхий улс бүс нутгийг ийн нэрлэдэг аж. Ерөнхийдөө аль ч улсад, хэн ч байгуулж бас ашиглаж болдог зүйл аж. Гэхдээ улстөрчид, орлого өндөртэй хүмүүс, алан хядагчид, хар тамхины наймаачид, томоохон бизнесмэнүүдэд орлогоо нуух, хууль бусаар олсон мөнгөө хадгалах, зарцуулах үүднээс оффшорыг ашигладаг юм байна.

Манай улсын хувьд оффшор бүсэд данстай байсан монгол иргэдийн нэрс олон нийтэд ил болсны дараа УИХ-ын гишүүн Сү.Батболд, Д.Цогтбаатар нар бидэнд оффшор дансанд мөнгө байхгүй. Харин оффшор бүсэд бүртгэлтэй байсан компанийн охин компаниас хувьцаа эзэмшиж байсан нь үнэн хэмээн мэдэгдсэн билээ. УИХ-ын гишүүн Сү.Батболдын хувьд “Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийн дагуу улстөрчид бизнесийн үйл ажиллагаанд шууд оролцохгүй, харин хөрөнгө оруулагч байж болдог. Бидний оролцсон энэ ажил бол хуулийн хүрээнд хийгдсэн. Хөрөнгө оруулалт хийсэн “Бату Майнинг” компани нь Монгол Улсад бүртгэлтэй. Энд үйл ажиллагаа явуулж байсан. Харин толгой компани нь Энэтхэгт үйл ажиллагаа явуулдаг юм байна. Бидэнд нуусан хаасан зүйл байхгүй. Хуулийн дагуу хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн. Энэ компанид би 11.9 хувийг эзэмшдэг байсан. 2003 онд нэрээрээ нээлттэй бүртгүүлж орсон. Би 18 мянга 771 ам.доллартай тэнцэх хувьцааг авсан. Тухайн үеийн ханшаар 20 гаруй сая төгрөг.

Энэ мөнгө миний хувийн данснаас гарсан. 2005 онд компанийн үйл ажиллагаа доголдож эхэлсэн учраас тус компанийн хувьцаа эзэмшигч байхаа больсон. Хөрөнгө орлогын мэдүүлэгт тусгах хууль 2007 оноос мөрдөж эхэлсэн учраас мэдүүлэх шаардлага байгаагүй. 2007 оноос хойш бүх компанийнхаа тухай мэдүүлэг өгч ирсэн” гэсэн бол сайд асан Д.Цогтбаатар “Надад оффшор данс байхгүй. Хариуцлагатай хэлье. Би Австралид төгссөн. Миний сайн найзууд Монголд хөрөнгө оруулалт хийж бизнес хийнэ гээд оруулж ирсэн.“Бату Майнинг” компани биднийг урьж, хувьцаа эзэмшиж, хамтарч бизнес хийсэн. Тэр үед гадны хөрөнгө оруулалт бараг орж ирдэггүй байсан.

Бид хөрөнгө оруулалт татах үүднээс хамтарч бизнес эхлүүлсэн. Ер нь гадны компаниудын ихэнх нь оффшор бүсэд бүртгэлтэй байдаг шүү дээ. Оюутолгойн "толгой" компани хүртэл оффшор бүсэд бүртгэлтэй байдаг. Гэхдээ хууль зөрчөөгүй. Хөрөнгө орлогын мэдүүлэгтээ яагаад мэдүүлээгүй вэ гэхээр би 2006 оноос хувьцаагаа татчихсан юм. Надад байгаа бүх хувьцааг би нэгд нэгэнгүй оруулж өгдөг. Монголын компанидаа л хийсэн хөрөнгө оруулалт байсан” гэв. УИХ-ын гишүүн асан С.Баярцогт Хятадын оффшор данстнуудын тоонд багтсан. Түүнийг хэвлэлээр нэг сая ам.доллар оффшор дансандаа мартсан гэцгээж байсан. Ийнхүү оффшорчид хөрөнгөө нуун дарагдуулж байхад ард түмний амьдрал өдөр ирэх тутам доройтож байна. Нэг зүйлийг сануулахад Монгол Улсын эдийн засгийг хэцүү байдалд оруулсан хүмүүс бол өнөөх оффшор дансанд хэдэн мянган ам.доллараа мартчихдаг хүмүүс байх юм. Аливаа нийгэмд улстөрчид нь бүтээн байгуулалтыг бий болгодог байхад манайд эсрэгээрээ улсын хөрөнгөөр идэж уусан олиргархиар дүүрчээ. Тиймээс эрх баригчдаас Оффшорчидтой тэмцэх хуулийн хэрэгжилт ямар байгаа талаар асуумаар байна. Ж.Батзандан гишүүний санаачилсан хуулийн төсөлд төрийн өндөр албан тушаалтнууд, төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагууд болон тэдний гэр бүлийн гишүүд, оффшор бүсэд данс эзэмших, мөн тус бүсэд байрлах аж ахуйн нэгж, байгууллагын хувьцаа эзэмшихийг хориглохоор тусгагджээ. Тиймээс бидэнд энэ хүмүүсийн толгойг илээд хараад суух биш шийтгэх ёстой мэт санагдана. Учир нь Монгол Улс хямраагүй, харин оффшорчид нь өнгөтэй өөдтэй бүхнийг хулгайлж одсон. Тиймээс оффшорчдийн харьд хадгалуулж байгаа мөнгийг татаж, хүүхэд багачуудын боловсрол, эрүүл мэндэд зарцуулахыг уриалж байна.



# МЭДЭЭЛЭЛ

## АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДАА

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас дараах үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, барилга байгууламжийн АНХНЫ албадан дуудлага худалдааг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 10.00 цагт албаны байранд зохион байгуулна. Оролцогчдыг 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 14.00 - 17.00 цагийн хооронд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны нэгдсэн өрөөнд бүртгэж дэнчинг хүлээн авна.

**Хаяг:** Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж
**Цахим хаяг:** http://www.nshga.cd.gov.mn, www.facebook.com/pages/Нийслэлийн-Шийдвэр-Гүйцэтгэх-Алба

| № | Үл хөдлөх эд хөрөнгийн хаяг байршил | Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан санал болгох доод үнийг тохиролцсон болон үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 70 хувь | Хариуцсан шийдвэр гүйцэтгэгч, утасны дугаар |
|---|---|---|---|
| | **ОРОН СУУЦ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖ** | | |
| 1 | Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, 2 дугаар хороолол, Нарны зам 27 дугаар байрны 12 тоот 35.07 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 40.708.275 | Ш.Бямбадорж 89086180 |
| 2 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-1 тоот 37.50 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 3 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-4 тоот 40.70 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 4 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-5 тоот 40.90 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 5 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-6 тоот 42.80 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 6 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-7 тоот 33.20 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 7 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, Нарны зам 51 дүгээр байрны мансардны 99В-10 тоот 44.50 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 14.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 8 | Хан-уул дүүргийн 1 дүгээр хороо, Туул гол гудамжны 62 дугаар байрны 06 тоот 88 м.кв талбайтай 3 өрөө орон сууц, 15 м.кв талбайтай автозогсоолын хамт | 242.760.000 | Ц.Чинтуяа 89086190 |
| 9 | Хан-уул дүүргийн 15 дугаар хороо, Үйлдвэр Туул гол гудамжны ХД-67 дугаар байрны 33 тоот 54.7 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 68.600.000 | Ц.Чинтуяа 89086190 |
| 10 | Хан-уул дүүргийн 2 дугаар хороо, Үйлдвэр ХД-Г 104 дүгээр байрны зоорийн давхарын 26 тоот 18.48 м.кв талбайтай автозогсоол | 12.880.000 | Э.Батхишиг 89086139 |
| 11 | Хан-уул дүүргийн 2 дугаар хороо, Үйлдвэр-2 ЧӨЧ 42 дүгээр байрны 09 тоот 63.3 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 73.500.000 | Э.Батхишиг 89086139 |
| 12 | Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Баянмонгол хороолол, 412 дугаар байрны 177 тоот 72.5 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 87.525.340 | Ц.Болормаа 89086186 |
| 13 | Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, ЭТӨЧ 76 тоот 431.6 м.кв талбайтай үл хөдлөх, 500 м.кв талбайтай газрын хамт | 379.990.000 | М.Золбоо 89086189 |
| 14 | Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Нарны зам 402 дугаар байрны 56 тоот 94.5 м.кв талбайтай 2 өрөө орон сууц, зоорийн давхарын 96 тоот 18 м.кв талбайтай автозогсоолын хамт | 245.000.000 | Ц.Болормаа 89086186 |
| 15 | Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Ургах наран хороолол, 8 дугаар байрны 14 тоот 41.20 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 31.937.010 | Б.Уранбаяр 89086164 |
| 16 | Баянгол дүүргийн 6 дугаар хороо, АОС гудамжны 78/а тоот 180 м.кв талбайтай граш, хувийн сууцны зориулалттай 2 давхар барилга 500 м.кв талбайтай газрын хамт | 280.560.000 | Д.Өлзийсайхан 89086166 |
| 17 | Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо, 12 дугаар хороолол, 103 дугаар байрны 604 тоот 109.34 м.кв талбайтай 4 өрөө орон сууц | 70.000.000 | О.Цэрэннадмид 89086163 |
| 18 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 5 дугаар байрны 5 тоот 250 м.кв талбайтай 90 хувийн гүйцэтгэлтэй аялал жуучлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 64.470.000 | И.Гомбожав 89086159 |
| 19 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 51 тоот аялал жуучлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 89.227.600 | И.Гомбожав 89086159 |
| 20 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 7 тоот 365 м.кв талбайтай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилгын үл хөдлөх хөрөнгө | 423.500.000 | И.Гомбожав 89086159 |
| 21 | Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Хоршоолол, Б.Дорж гудамжны 36/б дүгээр байрны 07 тоот 130.68 м.кв талбайтай хувийн сууц, 65 м.кв талбайтай граш, 131 м.кв талбайтай эзэмших эрхтэй газрын хамт | 245.000.000 | Б.Саяболд 89086132 |
| 22 | Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Хоршооллын хотхон, Б.Доржийн гудамжны 50 дугаар байрны 20 тоот 35 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 36.750.000 | А.Ганбаатар 89086134 |
| 23 | Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо, Москва хороолол, Москвагийн гудамжны 133/2 дугаар байрны 25 тоот 91.15 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 108.468.500 | Г.Ганбаатар 89086170 |
| 24 | Баянгол дүүргийн 17 дугаар хороо, 4 дүгээр хороолол, Л.Энэбишийн өргөн чөлөө 28/1 дүгээр байрны 59 тоот 39.47 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 41.443.500 | Г.Ганбаатар 89086170 |
| 25 | Баянгол дүүргийн 12 дугаар хороо 6 дугаар бичил хороолол 14 дүгээр байрны 69 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 175.000.000 | Б.Буянбадрах 89086144 |
| 26 | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 47/б байрны 22 тоот 102 м.кв талбайтай 4 өрөө орон сууц | 140.000.000 | Р.Азбаяр 89086146 |
| 27 | Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо, Титэм/18103/, 10б байрны 24 тоот 27.5 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 32.725.000 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 28 | Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороо, Титэм/18103/ 10в байрны В1 тоот 495 м.кв талбайтай үйлдвэр үйлчилгээний зориулалттай үл хөдлөх | 623.700.000 | Д.Мөнхбаяр 89086147 |
| 29 | Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, 2 дугаар хороолол, Төмөр замын 51 дүгээр байрны 5 тоот 29 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 56.000.000 | У.Энхсоёл 89086142 |
| 30 | Баянгол дүүргийн 7 дугаар хороо, 4 дүгээр хороолол, 29 дүгээр байрны 201 тоот 40 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 126.000.000 | У.Энхсоёл 89086142 |
| 31 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хорооолол, Намъяанжүгийн гудамжны 37 дугаар барилгын 5051 тоот 10.8 м.кв талбайтай худалдаа үйлчилгээний зориулалттай үл хөдлөх | 175.000.000 | У.Энхсоёл 89086142 |
| 32 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хорооолол, Намъяанжүгийн гудамжны 37 дугаар барилгын 5054 тоот 10.8 м.кв талбайтай худалдаа үйлчилгээний зориулалттай үл хөдлөх | 175.000.000 | У.Энхсоёл 89086142 |
| 33 | Баянгол дүүргийн 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс, Товчооны зам 51 дүгээр байрны 37 тоот 33 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 63.000.000 | У.Энхсоёл 89086142 |
| 34 | Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол, Жалханз Хутагт Дамдинбазарын гудамж 35 дугаар байрны 8 тоот 41.52 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 49.000.000 | Г.Идэрчулуун 89086143 |
| 35 | Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, 2 дугаар хороолол, 15 дугаар байрны 22 тоот 20 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 84.000.000 | Ж.Ариунзаяа 89086171 |
| 36 | Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, 2 дугаар хороолол, Төмөр зам гудамжны 52 дугаар байрны 55 тоот 29 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 112.000.000 | Ж.Ариунзаяа 89086171 |
| 37 | Баянгол дүүргийн 17 дугаар хороо, 4 дүгээр хороолол, 44/Д байрны 7 тоот 37.9 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 40.600.000 | Ж.Ариунзаяа 89086171 |
| 38 | Баянгол дүүргийн 18 дугаар хороо, 4 дүгээр хороолол, 47 байрны 38 тоот 29.1 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 32.592.000 | Ж.Ариунзаяа 89086171 |
| 39 | Багахангай дүүргийн 2 дугаар хороо, Өртөөний хэсэг, Шатахуун түгээх түгээгүүрийн байр 24 м.кв талбайтай үд хөдлөх, 6450 м.кв талбайтай газрын хамт | 70.000.000 | Ю.Оюунаа 89086182 |
| 40 | Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Зүүннарагийн 18 дугаар гудамжны 17 тоот 270 м.кв талбайтай машин угаалгын зориулалттай үл хөдлөх, 575 м.кв талбайтай газрын хамт | 133.000.000 | Ю.Оюунаа 89086182 |
| 41 | Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Бага тойруу, Сүхбаатарын гудамжны 12 дугаар байрны 1202 тоот 105.85 м.кв талбайтай оффисын зориулалттай үл хөдлөх, 47.7 м.кв талбайтай оффисын зориулалттай үл хөдлөх | 755.244.000 | Ю.Оюунаа 89086182 |
| 42 | Баянгол дүүргийн 2 дугаар хороо, 2 дугаар хороолол, Төмөр замын 67/5 дугаар байрны 1 тоот 75.35 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 350.000.000 | Ю.Оюунаа 89086182 |
| 43 | Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Нарны замын 404 дүгээр байрны 32 тоот 82.05 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 119.000.000 | В.Уранцэцэг 89086181 |
| 44 | Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 12 дугаар хороолол 47/б байрны 01 тоот 29.16 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 31.500.000 | Т.Амирдаа 89086168 |
| 45 | Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 7 дугаар байрны 39 тоот 29 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 70.000.000 | Б.Дэлгэрцэцэг 89086127 |
| 46 | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, ЭТӨЧ гудамжны 78 дугаар байрны 01 тоот 56 м.кв талбайтай үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө | 100.068.114 | Б.Эрдэнэболд 89086123 |
| 47 | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу гудамжны 32 дугаар байрны 41 тоот 17 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 44.917.224 | Б.Цэрэнчунт 89086124 |
| 48 | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу гудамжны 12/А дугаар байрны 21 тоот 57 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 175.000.000 | Б.Цэрэнчунт 89086124 |
| 49 | Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу гудамжны 15 дугаар байрны 13 тоот 22 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 84.000.000 | Б.Цэрэнчунт 89086124 |
| 50 | Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 12 дугаар хороолол, 7 дугаар байрны 1 тоот 38 м.кв талбайтай 4 өрөө орон сууц | 79.920.400 | Ч.Оюунбилэг 89086154 |
| 51 | Хан-уул дүүргийн 2 дугаар хороо, Үйлдвэр гудамжны 106/б байрны 124 тоот 42.36 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 61.231.100 | Ю.Отгонжаргал 89086157 |
| 52 | Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, Улаанхуаран гудамжны 13, 14 , 15, 16 дугаар байрнуудын зоорийн давхарт байрлах 12 ширхэг автозогсоолууд тус бүр | 7.700.000 | Ю.Отгонжаргал 89086157 |
| 53 | Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, Голден парк хотхон, ЭТӨЧ гудамжны 107 дугаар байрны 106 тоот 31 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 35.000.000 | Х.Саруул 89086185 |
| 54 | Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо, 7 дугаар хороолол, 24 дүгээр байрны 20 тоот 24 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 63.000.000 | Х.Саруул 89086185 |
| 55 | Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Олимпийн гудамжны 23 дугаар байрны 01 тоот 214 м.кв талбайтай орон сууц | 374.500.000 | П.Уранбилэг 89086153 |
| 56 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, ЭТӨЧ гудамжны 51/А байрны 68 тоот 37.63 м.кв талбайтай 1 өрөө орон сууц | 45.500.000 | П.Уранбилэг 89086153 |
| 57 | Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, 14 дүгээр хороолол, ЭТӨЧ гудамжны 51/Б байрны 27 тоот 56.7 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 67.200.000 | П.Уранбилэг 89086153 |
| 58 | Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо, 13 дугаар хороолол, 21 дүгээр байрны 210 тоот 30 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 57.120.000 | П.Уранбилэг 89086153 |
| 59 | Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Содномын гудамж, 54 дүгээр байрны 6 тоот 62 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 73.780.000 | П.Уранбилэг 89086153 |
| 60 | Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Содномын гудамж, 53 дугаар байрны 18 тоот 73.92 м.кв талбайтай 3 өрөө орон сууц | 110.943.053 | П.Уранбилэг 89086153 |
| 61 | Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо, 7 дугаар хороолол, 38 дугаар байрны 23 тоот 48 м.кв талбайтай 2 өрөө орон сууц | 63.000.000 | Б.Дэлгэрмөрөн 89086155 |
| 62 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 5 дугаар байрны 5 тоот 250 м.кв талбайтай 90 хувийн гүйцэтгэлтэй аялал жуучлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 64.470.000 | И.Гомбожав 89086159 |
| 63 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 51 тоот аялал жуучлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 89.227.600 | И.Гомбожав 89086159 |
| 64 | Хан-уул дүүргийн 11 дүгээр хороо, Богиноны ам гудамж, Дүнжингарав 7 тоот 365 м.кв талбайтай 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилгын үл хөдлөх хөрөнгө | 423.500.000 | И.Гомбожав 89086159 |
| | **ХАШАА БАЙШИН,ГАЗАР** | | |
| 65 | Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр баг, 79 дүгээр зөрлөг, Доргонотын хөндий 62.5 га газар | 107.800.000 | У.Энхсоёл 89086142 |
| 66 | Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр баг, 79 дүгээр зөрлөг, Доргонотын хөндий Услалтын системийн зориулалттай үл хөдлөх | 67.200.000 | У.Энхсоёл 89086142 |
| 67 | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Ар согоотын 1 дүгээр хэсэг гудамжны 1-113 тоот 700 м.кв талбайтай зуслангийн зориулалттай газар | 14.000.000 | Б.Дэлгэрцэцэг 89086127 |
| 68 | Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Ар согоотын 1 дүгээр хэсэг гудамжны 170 тоот 51 м.кв талбайтай хувийн сууц, 700 м.кв талбайтай газрын хамт | 28.000.000 | Б.Дэлгэрцэцэг 89086127 |
| 69 | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо, Хайлаастын 6 дугаар гудамжны 54 тоот 40 м.кв талбайтай хувийн сууц, 6 х 4 хэмжээтэй 2 хувийн сууц, 681.41 м.кв талбайтай газрын хамт | 35.000.000 | Т.Амирдаа 89086168 |
| 70 | Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Зүрх уул 2 дугаар гудамжны 547 тоот 24 м.кв талбайтай хувийн сууц, 252 м.кв талбайтай газрын хамт | 42.000.000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 71 | Хан-уул дүүргийн 4 дүгээр хороо, Нүхтийн зам гудамжны 8/Б тоот 307 м.кв талбайтай хувийн сууц | 1.050.000.000 | Ж.Оюунжаргал 89086119 |
| 72 | Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Сансарын 1 дүгээр гудамжны 1 тоот 72 .мкв талбайтай 2 давхар барилга, 700 м.кв талбайтай газрын хамт | 35.096.390 | Ч.Батмөнх 89086161 |
| 73 | Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоотын 79 дүгээр гудамжны 1106 тоот 48 м.кв талбайтай хувийн сууц, 555.49 м.кв талбайтай газрын хамт | 13.300.000 | М.Золбоо 89086189 |
| 74 | Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Сэлбийн 7 дугаар гудамжны 153 тоот 227 м.кв талбайтай хувийн сууц, 290 м.кв талбайтай газрын хамт | 35.000.000 | Ц.Цолмонтуяа 89086158 |
| 75 | Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Чулуут АОС 1 дүгээр гудамжны 70 тоот 107 м.кв талбайтай хувийн сууц, 27 м.кв талбайтай граш, 368 м.кв талбайтай газрын хамт | 39.900.000 | Б.Наранчимэг 89086165 |
| 76 | Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Хилчин 23 дугаар гудамжны 08 тоот 100 м.кв талбайтай хувийн сууц, 497 м.кв талбайтай газрын хамт | 16.839.830 | М.Март 89086128 |
| 77 | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Хандгайтын 230/1 тоот 108 м.кв талбайтай 2 давхар хувийн сууц | 70.000.000 | И.Гомбожав 89086159 |
| 78 | Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Тахилтын 3 дугаар гудамжны 39 тоот 229.5 м.кв талбайтай хувийн сууц болон граш, 700 м.кв талбайтай газрын хамт | 48.440.000 | М.Март 89086128 |
| 79 | Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Сонсголон 17 дугаар гудамжны 631 тоот 70 м.кв талбайтай хувийн сууц, 469 м.кв талбайтай газрын хамт | 17.500.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 80 | Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Чулуутын 6 дугаар гудамжны 144 тоот 382.2 м.кв талбайтай хувийн сууц, 700 м.кв талбайтай газрын хамт | 105.000.000 | Ш.Бямбадорж 89086180 |
| 81 | Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороо, Хилчин 44 дүгээр гудамжны 108 тоот 700 м.кв талбайтай гэр бүлийн хэрэгцээний газар | 4.900.000 | Ч.Оюунбилэг 89086154 |
| 82 | Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо, Дамбадаржаагийн 30 дугаар гудамжны 346 тоот 390 м.кв талбайтай эзэмших эрхтэй газар | 8.337.000 | Б.Золбоо 89086184 |
| 83 | Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Их булагт байрлалтай 200000 м.кв талбайтай газар | 560.000.000 | П.Уранбилэг 89086153 |
| 84 | Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо, Хандгайтын 25 дугаар гудамжны 138 тоот 32 м.кв талбайтай хувийн сууц, 359 м.кв талбайтай гэр бүлийн хэрэгцээний газрын хамт | 18.480.000 Н.Цэрэнсодном 89086152 | |
| 85 | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Чингэлтэйн 13 дугаар гудамжны 418 тоот 70 хувийн гүйцэтгэлтэй 256.5 м.кв талбайтай хувийн сууц | 78.400.000 | Н.Эрдэнэбулган 89086125 |
| 86 | Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Дарь Эхийн 8 дугаар гудамжны 5 тоот 30 м.кв талбайтай хувийн сууц, газрын хамт | 11.200.000 | Н.Эрдэнэбулган 89086125 |
| 87 | Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо, Чингэлтэйн 7 дугаар гудамжны 177/А тоот 38 м.кв талбайтай хувийн сууц, 700 м.кв талбайтай газрын хамт | 24.500.000 | Н.Эрдэнэбулган 89086125 |

**Жич: Албадан дуудлага худалдааны дэнчингийн мөнгийг Улаанбаатар банкны 267001560 тоот дансанд тушааж нэг хувийг авчирна уу.**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



# ИРГЭД ҮҮРГЭЭ МЭДДЭГ Ч, ХААНА ХАНДАХАА МЭДЭХГҮЙ ГЭВ

Н.БАТЗАЯА

Манай улсын иргэдийн дунд гэр бүлийн хүчирхийлэл гэх ойлголт аль хэдийнэ танил болсон билээ. Үүнтэй холбогдуулан хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хэрвээ хөршийн тань хаалттай хаалганы цаана гэр бүлийн хүчирхийлэл явагдаж байвал нэн даруй холбогдох байгууллагад мэдэгдэх талаар иргэдэд үргэлж анхааруулдаг. Тиймээс "Монголын мэдээ" сонин иргэдээс гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх, хаана хандах зэргийг асууж, "Speak out" бэлтгэлээ.

### Н.Өнөржаргал: Эхлээд хаалгыг нь тогшоод "Эхнэр хүүхдээ зодохоо боль. Цагдаа дуудлаа шүү" гэж анхааруулна



*/Баянгол дүүргийн иргэн/*

-Мэдээж иргэн хүнийхээ хувьд мэдээлэл өгөлгүй яах вэ. Манай Монголчууд гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хүндээр тусгаж авдаг. Ихэвчлэн айл гэрийн асуудалд хөндлөнгөөс оролцохгүй гэсэн бодолтой байдаг. Миний хувьд огт өөр үзэл бодолтой явдаг. Би үнэхээр хүүхэд уйлах, эмэгтэй хүн орилохыг сонсвол тэдэнд туслах юмсан гэж их санаа зовдог. Ер нь амьдрал баян учраас айл гэрт хэрүүл болно. Эхнэр, нөхөртэйгөө таарч тохирохгүй, бие биеэ хардах зэрэг тохиолдол гарна шүү дээ. Гэхдээ тэр бүхний хамгийн хүнд хохирогч нь хүүхэд байдаг. Аав, ээжийн хоорондоо хэрэлдэж, муухай орилоход хүүхэд айж, уйлна. Их хэцүү. Тиймэрхүү зүйл сонсож, өөрийн нүдээр харахад сэтгэл эмзэглээд хэцүү байдаг. Би өмнө нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй хүнтэй таарч байгаагүй. Тиймээс энэ талаархи мэдээллийг хаана өгөх, ямар байгууллагад хандах ёстойг сайн мэдэхгүй байна. Хэрвээ манай хөрш айлд хүчирхийлэл гарвал эхлээд хаалгыг нь тогшоод "Эхнэр хүүхдээ зодохоо боль. Цагдаа дуудлаа шүү" гэж анхааруулга өгнө. Ийм л зүйл хийх байх даа. Өөрөөр ямар арга хэмжээ авах ёстойг сайн мэдэхгүй байна. Эсвэл гэрээсээ гүйж гараад ойр орчимд байрлах цагдаад хэлнэ. Зарим шөнө эмэгтэй хүн уйлах, туслаач гэж хашгирах чимээ сонсогддог. Тэгэхээр нь цонхоороо "Болиоч. Цагдаа дуудлаа шүү" гэж хашгирдаг. Хэсэг байж байгаад чимээгүй болчихдог. Чимээгүй болчихвол үр дүнтэй болсон юм шиг санагддаг. Миний хувьд өөрийн хэмжээнд ийм арга хэмжээ авна даа.

### Д.Отгонцэцэг: Цагдаа ирдэг ч юм уу, үгүй ч юм уу мэдэхгүй юм

*/Чингэлтэй дүүрэг/*

-Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг хаана өгөхийг сайн мэдэхгүй байна. Миний мэдэж буйгаар 102 дугаарын утсанд мэдээлэл өгнө. Хэрвээ хүүхэд уйлж, хүчирхийлэлд өртвөл 108 дугаарын утсанд мэдэгдэх ёстой талаар сонсож байсан. Өөр хаана хандах ёстойг мэдэхгүй байна. Би өмнө нь нэг удаа гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн. Манайх орон сууцанд амьдардаг л даа. Сүүлийн үеийн орон сууцны хана их нимгэн болсон. Түүнээс болж хажуу айлд болж байгаа бүх зүйл бидэнд сонсогддог. Манай дээд талын айл их хэцүү. Үргэлж л түчигнэчихнэ. Ихэнхдээ түчигнэхийг нь тэвчээд хүлээнэ. Гэртээ намдахыг нь хүлээгээд л суучихдаг. Бүр болохгүй бол цагдаа дууддаг. Гэхдээ цагдаа ирдэг ч юм уу, үгүй ч юм уу мэдэхгүй юм. Ямартай ч дуудлага өгөх нь өгдөг. Хэр их ноцтой чимээ шуугиантай байгаагаас л хамаарна. Аяндаа айхтар ширүүн хэрүүл анзаарагдана шүү дээ. Нэг их айхтар хэрүүл болоогүй бол хүүхэд уйлахгүй. Тэгэхээр нь дуудлага өгөлгүй орхичихдог. Хүмүүс ч гэсэн гэр бүлийн хүчирхийлэлтэй таарвал дуудлага, мэдээлэл өгөөсэй гэж боддог.



### Ч.Мөнхномин: Хэн нэгэн хүн зовж явахад зүгээр хараад сууж болохгүй

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Хэрвээ манай гэрийн ойролцоо амьдардаг хөрш айлуудад гэр бүлийн хүчирхийлэл гарвал би цагдаад мэдээлэл өгнө. Учир нь энэ бол иргэн хүний үүрэг. Бидэнд ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртвөл Хүүхдийн 108 дугаарын утсанд хандах ёстой талаар хичээлийн үеэр багш хэлдэг. Ийм л зүйлийг би мэднэ. Үүнээс өөр хаана хандах эсэхийг сайн мэдэхгүй юм. Миний бодлоор сургуулийн маань хойд талд хорооны байр байдаг л даа. Тэр хорооны ажилчдад хандаж болох байх. Мөн цагдаад хандаж болно. Миний мэдэж буйгаар аюул тохиолдсон үед хандах газрууд энэ л байна. Зарим хүмүүс гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх нь буруу гэж ярьдаг. Гэхдээ би зовлон тохиолдсон нэгэнд туслах нь зөв гэж боддог. Хэн нэгэн хүн зовж явахад зүгээр хараад сууж болохгүй. Тиймээс хэрвээ надтай эхнэр, хүүхдээ зодож байгаа хүн таарвал цагдаад л мэдээлнэ.



### Х.Баянбилэг: цагдаагийн 102 утсанд дуудлага өгнө

*/Сүхбаатар дүүрэг/*

-Тийм. Мэдээлэл өгөх нь зөв гэж боддог. Гэхдээ учиртай мэдээлэл өгөх нь зөв болов уу. Олон жил айл саахалт явсан хүмүүсийнхээ зан аашыг бид мэддэг болчихдог. Тэр хүн өмнө нь архи дарс ууж, агсам согтуу тавьдаг байсан уу, эхнэр хүүхдээ зодож, дарамталдаг уу гэдгийг олон жил хөрш явсан хүмүүс андахгүй мэднэ. Тиймээс хөрш маань урьд өмнөхөөсөө илүү давраад байвал мэдээлэл өгнө. Өөрөөр хэлбэл, өмнө нь архи уусан ч шууд унтдаг байснаа эхнэр, хүүхэддээ гар хүрч, эргэн тойрныхондоо төвөг уддаг болчихвол шууд мэдээлнэ. Харин хоорондоо маргалдаж, хэрэлдсэн ч нэгэндээ гар хүрэхгүй дуугүй болчихвол мэдээлэхгүй. Үнэхээр муухай ааш араншин гаргаад эхнэр, хүүхдээ зодож, дарамтлаад байвал зохих газарт нь мэдэгдэнэ.



### Р.Ренчиндулам: Хууль хяналтынхан гэлтгүй ард иргэд, бид ч гэсэн чухал оролцоотой байх ёстой

-Гэр бүлийн хүчирхийллийг иргэд харсан ч мэдээлэхгүй байх нь буруу гэж боддог. Энэхүү хэргийг цагдаад мэдэгдэж түргэн шуурхай арга хэмжээ авахгүй бол гэр бүлийн хүчирхийлэл улам л газар авсаар байх болно. Тиймээс би манай хөрш айлд гэр бүлийн хүчирхийлэл болбол цагдаагийн газрын 102 дугаарын утсанд мэдэгдэнэ. Зарим хүмүүс харсан ч хараагүй юм шиг л дуугүй өнгөрдөг. Магадгүй энэ нь бидний уламжлалт сэтгэлгээтэй холбоотой болов уу гэж боддог. Дээр үед чинь л эхнэр, нөхрийн хэрэгт бүү оролц гэж ярьцгаадаг байсан. Одоо цаг үе өөрчлөгдөж байна. Түүнээс болж залуучуудын харилцаа ч өөрчлөгдсөн. Гэр бүлийн хүчирхийлэл гэхээр хүний амь насны хэмжээнд яригдах болсон. Амиа алдсан хүний тоо ч ихсэх болсон гэж сонссон. Тэгэхээр үүнд зөвхөн хууль хяналтынхан гэлтгүй ард иргэд бид ч гэсэн чухал оролцоотой байх ёстой гэж хувьдаа боддог. Тэгж байж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчидтэй тэмцэж чадна.



### Э.Сүхбаатар: Цагдаагийн газарт мэдээлнэ

-Хэрвээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй тохиолдолтой таарвал мэдээлнэ. Гэхдээ Гэр бүлийн хүчирхийллийн төвийн утсыг сайн мэдэхгүй. Тиймээс цагдаагийн газрын 102 дугаарын утсанд мэдэгдэж, арга хэмжээ авна. Зарим хүмүүс мэдээлэхгүй, надад хамаагүй гэдэг юм. Гэхдээ тэр бол хэтэрхий амин хувиа хичээсэн бодолтой байна гэсэн үг. Бусдын оронд өөрийгөө тавьж үздэггүй. Ийм зүйлийн дараа ямар үр дн гарч болох талаар огтхон боддоггүй. Тийм байж болохгүй. Ямар нэгэн байдлаар өөрийнхөө хэмжээнд туслах л хэрэгтэй. Мөн ёс бус зүйлтэй тэмцэх нь иргэн хүний үүрэг гэж боддог.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

# ЦАГ ҮЕ

Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## Татвар төлөгчдийн өдөрлөгийг зохион байгуулав

Т.БОЛДБААТАР

Алсдаа гэх юмгүй ойрмогхоны нэг, хоёр жилдээ багтаж санаачлагчдын хүсэл төсөөллөөр хол ойрынхон байтугай хилийн чанадын улс орнуудын жуулчид хөл дарах “Боржигин цогцолбор”-ын он шав тавьсан дэвсэгт аймгийн Татварын хэлтсийнхэн хаврын адаг сарын сэвэлзүүр салхитай амралтын өдрөөр татвар төлөгчдийн өдөрлөгийн нээлтийг хийв. Халхын боржигин сэцэн вангийн хошууны арван ноёны отгон буюу цор ганц угсааны бус Гомбосүрэн ноёны Тамгын газар төрийн алба залгуулж асан Өлзийтийн голд энэ хэлтсийнхэн МЗЭ-ийн гишүүн, чөлөөт уран бүтээлч Б.Мөнх-Өлзийгийн дэглэсэн хошуу ноён, хатан, отгийн занги, шивэгчин, туслах, тал бичээч нарын дүрд хувилахдаа “Эзэн Богд хошууны наадамд морилох болсон учир алба гувчуурын дутууг бүрдүүлэн тушаах” ноёны даалгаврыг биелүүлсэн юм.

Дараа нь азын 13 морь уралдуулж, гар бөх барилдуулж, нум сур харваж, ур чадвар, овсгоо самбаа, уран мэхээрээ уралдахад хэлтсийн эдийн засагч М.Буяндэлгэр, улсын байцаагч Ц.Наранжаргал, нягтлан бодогч Д.Жаргалсүрэн нар тэргүүллээ. Хошуу ноёны нүүдлийн замд алба гувчуурын асуудлаар хэрэг хэлэлцсэн П.Энх-Оюун даргатай тус хэлтсийнхэн Боржигин цогцолборын анхны гийчин баг байсан төдийгүй тэргүүний татвар төлөгч “Дугуй дэлгүүр” ЗБН, “Жанчин чойрын данжин сахиус” ТББ, “BNZ” ХХК-ийн төлөөллүүд оролцлоо. Энэ үеэр Өлзийтийн голд 20 гаруй жил нутаглаж байгаа “Бужгар” Батчулуун гуайн хүү Түвшин талархал илэрхийлж, цогцолборын бүтээн байгуулалтад 50.0 мянган төгрөгийн хандив өргөлөө.

## Математикийн улсын 53 дугаар олимпиадад амжилттай оролцлоо




Математикийн улсын 53 дугаар олимпиад Булган аймагт болж өндөрлөлөө. Энэ удаагийн олимпиадыг Монгол Улсын Гавьяат багш С.Шагдарын нэрэмжит болгон Монголын математикийн олимпиадын хороо, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, “Шагдар багш” сан хамтран зохион байгуулсан байна. Нийт 21 аймаг, есөн дүүргээс багш, хүүхдүүд оролцсон тус олимпиадаас Говьсүмбэр аймгийн бага ангийн багшийн төрөлд Д.Нарангэрэл 6 дугаар байр, дунд ангийн багшийн төрөлд Г.Байгальмаа 25, 10 дугаар ангийн төрөлд Хонгорзул 26 байранд тус тус оржээ. 2018 оны улсын олимпиадыг Дорноговь аймагт зохион байгуулахаар болж, шилжин явах тугаа гардан авсан байна.

## Багш нарт сургалт явуулав

“Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёл, урлагийн газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага Бор-Өндөр-1 ОНХХ хамтран сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, Политехник коллежийн нийт 254 багш нарын дунд сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Сургалт, хэлэлцүүлгийг БСШУСЯ-ны Бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Л.Отгонсүрэн, ”Шинэ монгол” олон улсын сургуулийн захирал Б.Амартүвшин, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын төлөвлөлт, мониторингийн албаны дарга Р.Золзаяа нар ”Багшийн ёс зүй хариуцлага, хандлага” сэдвээр явууллаа.

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# Ц.ГАНЗОРИГ: БИДНИЙ ХӨГЖИЛ, 10 ХУВЬ

Б.ОЮУН-ЭРДЭНЭ

*“Зөнгийн хүүхдүүд”, “Зөнгийн тусламж” гэх ойлголт нийгэмд тархаж “Зөнд харьяалагдах” хүсэлтэй хэсэг бүлэг иргэд олон. Гэтэл монгол хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, амьдрах орчны хөгжлийн асуудлаар “Дэлхийн Зөн” ОУБ олон хөтөлбөр хэрэгжүүлж үйл ажиллагаа явуулсан ч нийгэм тэднийг “тусламжийн, халамжийн байгууллага” гэж харсаар, ойлгосоор иржээ. Энэ хандлагыг өөрчлөх гэж тэд “мэдээллийн нөлөөлөл” хийгээгүй. Харин мэдлэгийн нөлөөллөө чимээгүй явуулсаар байна. Дэлхийн Зөн ОУБ-ын Эрдэнэт- Нутгийн хөгжлийн хөтөлбөрийн удирдагч Ц.Ганзоригтой уулзлаа. Тэрбээр Дэлхийн Зөнгийн үйл ажиллагааг “90 хувь нь хөгжил, 10 хувь нь халамж байдаг” гэж товч бөгөөд тодорхой хариулсан юм.*

**-“Миний амьдралыг өөрчилж, тусалж дэмжсэнд баярлалаа. Одоо биеэ дааж амьдрах цаг минь ирсэн. Энэ өдрөөс эхлээд “Зөнгийн хүүхэд” гэсэн “харьяалалд” хамрагдахгүй боллоо” гэж хэлээд танайхаас туурга тусгаарласан айл өрх олон байна уу?**

-Байлгүй яах вэ. Зөвхөн Эрдэнэтэд маш олон өрх өөрсдийн сайн дураар манай хөтөлбөрөөс гарсан. Өөрөөр хэлбэл, танай байгууллагын дэмжлэггүйгээр цаашид амьдралаа авч явж чадна, олон жил дэмжиж, тусалж, хөгжүүлж байсанд баярлалаа гэж хэлээд “туурга тусгаарласан” айл өрх олон бий. Хүүхдүүд нь ч “Зөнд харьялагддаг” гэдгээ нууж эхэлдэг юм билээ. Энэ бол хувь хүний бардам зангаас гадна манай байгууллагаас олж авсан олон мэдлэгийн хүрээнд иймитгэлийг олж авсан байдаг. Бидний зорилго хүүхэд бүрийн бүрэн дүүрэн амьдралын төлөө чиглэсэн байдаг. Энэ зорилгыг хэрэгжүүлэх, амьдралынхаа мөрдлөг болгохоо ухамсарласан айл өрх, иргэд туурга тусгаарлаж, цаашид сайн дураараа ямар ч цалин, урамшуулалгүйгээр бидний ажилд тусалдаг. Ийм сэтгэлтэй, санаачилгатай иргэд олон байгаасай гэж манай байгууллага хүсдэг.

**-Тэгвэл танай харьяалалд байнга байхыг хүсдэг хүн олон бий юу?**

-Олон. Гэхдээ энд нэг зүйлийг ойлгох хэрэгтэй. Халамж, хөгжил хоёр өөр. Бидний үйл ажиллагааны 90 хувь нь хөгжил, 10 хувь нь халамж руу чиглэсэн байдаг. Тиймээс хүүхэд, өрхөд чиглэсэн хөтөлбөр бол хөгжлийн төлөө юм. Гэтэл иргэд 10 хувийн халамжийг хараад ямар нэг материаллаг зүйл хүртэхийн тулд манайд харьялагдахыг хүсдэг. Бид гэнэтийн болон зайлшгүй шаардлагатай тохиолдолд бага зэргийн халамж өгдөг. Харин цаашид хэрхэн биеэ дааж амьдрах вэ, эрсдэлд өртөхгүйн тулд өрх юунд бэлэн байх ёстой вэ, хүүхдийн эрх, хамгааллын төлөө юу хийж чадах вэ, гэр бүлийн боловсрол яагаад миний амьдралд чухал вэ гэдгийг ойлгох, ойлгуулахад манай байгууллагын үйл ажиллагаа чиглэгдэж байдаг. Өөрөөр хэлбэл, бидний өдөр тутам хийж буй ажлын 90 хувь нь өрх, хувь хүн, хүүхэд, улс орны хөгжлийн төлөө байдаг. Хөгжил бол өөртөө байхгүй зүйлийг бий болгох, цаашид бусдын төлөө ямар нэгэн сайн зүйлийг хийх чадалтай болох тухай л ярьж байгаа юм. Хөгжил бол өөртөө байхгүй зүйлийг бий болгох, цаашид бусдын төлөө ямар нэгэн сайн зүйлийг хийх чадалтай болох тухай л ярьж байгаа юм.

**-Гэхдээ нийгэм та нарыг халамжийн байгууллага л гэж хардаг шүү дээ?**

-Тийм ээ. Гэхдээ манайхыг илүү сайн мэддэг хүмүүс нь өөрөөр хардаг. Дийлэнх нь тэгж хардаг. Харин одоо бид энэ ойлголтыг өөрчлөхийн төлөө ажиллаж байна.

**-Нэгэнт тогтсон хандлагыг өөрчлөхөд хэцүү. Ялангуяа 20 гаруй жил үйл ажиллагаа явуулсан танай байгууллага хүүхдийн хөгжлийн төлөө ажилладаг гэж одоо хэлэхэд ойлгох болов уу. Тусламж, дэмжлэг хайсан хүнд биш, мэдлэг, боловсрол хайсан өрх, хувь хүнд тусалдаг гэдгээ яаж ойлгуулах вэ?**

-Бид анхнаасаа олон нийтэд хүргэх мэдээлэлдээ биш, ажлын амжилт үр дүн рүүгээ хэтэрхий анхаарсан нь бидний буруу ч байж магадгүй. Өөрсдийгөө нийгэмд зөв ойлгуулахын төлөө мэдээлэл бэлтгэсэнгүй. Энэ бидний алдаа байх. Одоо халамжийн биш хөгжлийн байгууллага гэж хэлээд ч иргэд ойлгохгүй байна. Ойлголтын энэ зөрүү заримдаа ажилд маань тээг болдог. Өнгөрсөн хугацаанд гадна, дотны сайн туршлага, аргуудыг Монголын хөрсөнд буулгалаа. Амжилттай хэрэгжсэн зүйлүүд бий. Гэхдээ л бид туршлага хуримтлуулсан. Туршлагаас хуримтлуулсан мэдлэгээ ойлгуулах хэрэгтэй байгаа. Мөн цаашид Дэлхийн Зөнгийн үйл ажиллагааг хэнд шилжүүлэх вэ гэдэгт анхаарч байна. Хүүхэд бүрийн бүрэн дүүрэн амьдралын төлөө төр ажиллах уу, иргэд үү эсвэл өрх гэр үү. Энэ л бидний дараагийн зорилт.

**-Тэгвэл 90 хувийн хөгжлийнхөө талаар яриач?**

-Бид олон улсын хөгжлийн аргачлалууд дээр үндэслэж, Монголын нөхцөлд тохирсон хөтөлбөрөө боловсруулдаг. Жишээ нь, 10 орчим жилийн өмнө “Гэр” аргачлал гэж хийсэн. Үүнийг амжилттай хэрэгжүүлсний үндсэн дээр Засгийн газраас “Зорилтот өрхийн хөгжил, хамгаалал”-ыг сайжруулах Үндэсний хөтөлбөр боловсруулагдсан. Мөн өрхийн даван туулах “Төгсөлт” гэдэг


# ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ АЛБАДАН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас доорх үл хөдлөх эд хөрөнгийн анхны албадан дуудлага худалдааг 2017 оны 05 дугаар 24-ний өдрийн 11:00 цагт зохион байгуулна.

| Д/д | Эд хөрөнгийн байршил | Хэмжээ | Зориулалт | Байршил | Харилцан тохиролцож тогтоосон, үнэлгээчний тогтоосон үнэ | Дуудах үнэ Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д заасны дагуу харилцан тогтоосон, нэлгээчний тогтоосон үнийн 70% | Шийдвэр гүйцэтгэгч |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баяншанд багийн 6 дугаар гудамжны 11 тоот хаягт байрлах улсын бүртгэлийн Ү-0518000005 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000172253 дугаар гэрчилгээтэй, гэр бүлийн хэрэгцээний газар, улсын бүртгэлийн Ү-0518002349 дугаарт бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000202928 дугаар гэрчилгээтэй, дэлгүүрийн зориулалттай хувийн сууц | Газар 1142,29м2 Хувийн сууц 160м2 | Гэр бүлийн хэрэгцээний газар, хувийн сууц, дэлгүүр | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баяншанд багийн 6 дугаар гудамжны 11 тоот | 40728124 | 28194686 | Г.Мөнхзул 89086018 |
| 2 | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баяншанд багийн 5 дугаар гудамжны 40 тоот хаягт байрлах улсын бүртгэлийн Ү-0518000616 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000064482 дугаар гэрчилгээтэй, гэр бүлийн хэрэгцээний газар, улсын бүртгэлийн Ү-0518002348 дугаарт бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 000202927 дугаар гэрчилгээтэй дэлгүүрийн зориулалттай байшинтай хашаа | Газар 700,0м2 Амины орон сууц 63м2 | Гэр бүлийн хэрэгцээний газар, дэлгүүрийн байшинтай хашаа | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Баяншанд багийн 5 дугаар гудамжны 40 тоот | 11786262 | 8250383 | Г.Мөнхзул 89086018 |
| 3 | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат багийн 12 дугаар гудамжны 17 тоот хаягт байрлах улсын бүртгэлийн Ү-0518000647 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 00073611 дугаар гэрчилгээтэй гэр бүлийн хэрэгцээний газар, улсын бүртгэлийн Ү-0518000862 дугаарт бүртгэгдсэн, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 0001212285 дугаар гэрчилгээтэй өвлийн орон сууц | Газар 1767,0м2, өвлийн орон сууц 153м2 | Гэр бүлийн хэрэгцээний газар, амины орон сууц | Говь-Алтай аймаг Есөнбулаг сумын Харзат багийн 12 дугаар гудамжны 17 тоот | 33777656 | 23644359 | Г.Мөнхзул 89086018 |

**Хаяг:** Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Оргил баг Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хурлын зааланд болно.

**Жич:** Дэнчин болох үнийн дүнгийн 10 хувийг 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 15:00 цаг хүртэл албаны дансанд бэлнээр тушааж, бүртгүүлсэн байна.

**Харилцах утас:** 89086018, 89086310

## ЦАГ ҮЕ

аргачлал байна. Энэ нь гурван жилийн хугацаатай. Энэ хугацаанд өрхийн амьжиргааны төвшин дээшилж “амьдралын сургуулийг” төгсөнө гэсэн үг юм.

**-Өнгөрсөн хугацаанд хийсэн ажлаа дүгнэж ярьвал олон зүйл хэлэх байх. Дэлхийн Зөн Монголын хөгжилд ямар хувь нэмэр оруулсан гэж та бодож байна вэ?**

-Монгол Улсын хөгжлийн тодорхой орон зайг бид нөхөж яваа. Төрийн байгууллага болон хэн нэгний хийгээгүй орон зайг нөхөж, дүүргэсэн гэж бодож байна. Одоо энэ орон зайг иргэдээр өөрсдөөр нь дүүргэх зорилт тавьж байгаа. Тодруулбал, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Харин үр дүнгийн талаар ярьвал их зүйл бий. Монгол Улсын хөгжлийн тодорхой орон зайг бид нөхөж яваа.

**-Жишээ нь Эрдэнэт хот, хувь хүний хөгжил, өрх гэрт ямар өөрчлөлт бий болгов?**

-Хүүхэд гэр бүлтэйгээ

Энэ зөвхөн Эрдэнэт хотод хийгдсэн ажил биш. Монгол Улсын хэмжээнд салбараараа дамжуулж хийсэн ажил байгааг бас ойлгох хэрэгтэй. Жишээ нь, Монгол Улсад Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага бий болсон. Гэр бүл, хүүхдийн асуудлыг тусад нь салгаж авч үзэж болдоггүй гэдгийг төсөл хэрэгжүүлэх замаар шийдвэр гаргагчдад ойлгуулж чадсан нь Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийг буюу төрийн нэгдсэн институтийг бий болгоход хувь нэмрээ оруулсан. Хүүхэд, гэр бүлийн асуудлыг хэзээ ч тусад нь авч үзэж болохгүй.

**-“Гэр бүлийн хүчирхийллэтэй тэмцэхтухай хууль”-ийн санаачилга танай байгууллагаас гарч байсан гэж сонссон юм байна?**

-Бид 20 гаруй жил хүүхэд, гэр бүлийн асуудлыг шийдэх гэж ажилласан. Энэ хугацаанд Монголын хууль, журам учир дутагдалтай байсан. Иймд гэр бүлийн үндэсний чуулган зохион байгуулж түүнээс гарсан зөвлөмж, санаачилгаар

Ойрын жишээ гэхэд, өнгөрсөн гурван жилийн хугацаанд Орхон аймагт хүлэмжийн аж ахуйн төсөл амжилттай хэрэгжсэнээр олон хүн ажлын байртай болж, өрхийн орлогоо нэмэгдүүлж чадсан.

**-Цаашид цэгцэлмээр, өөрчилмөөр ажил юу байна вэ?**

-Асуудал олон байна. Одоо идэвхтэй буюу өөрийнхөө болон бусдын төлөө бүтээлч, хүчтэй байж чадах орон нутгийн иргэдийг бий болгох нь бидний дараагийн зорилт. Хүүхэд хамгаалал,өрхийн амьжиргааны төвшинг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ажлуудад илүү анхаарах хэрэгтэй байна. Эдгээр асуудлыг шийдэхэд иргэдийн оролцоо, сайн дурын ажил хийх нь маш чухал. Түүнээс биш төр, олон улсын байгууллага ажиллаад, ажиллаад үүнийг шийдэж чадахгүй.

**-Товчхондоо, та “аминдаа арчаатай хүн, өрх”-ийн талаар яриад байна аа даа. Ийм хүн олон болж байна уу?**

байх нь дотоод нөхцөл юм. Ийм чадвартай гэр бүлийг бий болгох гэж бид зорьж байгаа. Арай гэж амьдралаа босгоод дээшлүүлж байтал гэнэтийн гал түймэр, гамшиг ослын үед өрх гэрээ сүйтгүүлж дахин эхнээс нь эхлэх шаардлагатай болдог. Их харамсалтай. Давхар сэтгэл санаа, эрүүл мэндээрээ ч хохирдог. Ийм байдал үүсгэхгүй л байх, ийм зүйлд бэлэн байдлаа хангах нь чухал юм.

### Миний ажил 100 хувь ханлага шаарддаг

**-Та англи хэлний багш мэргэжилтэй. Багшаас заах арга зүй ур чадвар шаардагддаг бол “Дэлхийн Зөн”-ийн ажилтан, зохицуулагчид ямар ур чадвар шаардлагатай байдаг вэ?**

-Ямар ч ажил ур чадвар, мэдлэг шаарддаг. Харин сүүлийн үед хандлага их чухал болжээ. Нэг хувийн чадвар 99 хувийн хандлага гэж ярьж

бусдад тусалж болохыг олж харсан. Дэлхийн Зөн”-ийн хийж байгаа ажил бүр утга учиртай, үнэ цэнэтэй байсан. Ажлаараа дамжуулж бусдад тусалж болохыг олж харсан.

**-Таныг анзаараад байхад байгууллагынхаа нэршлээр их ярих юм. Жишээ нь, танай төсөл, хөтөлбөр, уриа их сонин нэртэй юм билээ. Энэ нь монгол хүний ойд шууд буухгүй юм. Та нар хэзээнээс энгийн байдлаар ярьж өөрсдийгөө зөв ойлгуулж эхлэх бол. Магадгүй ийм хэллэг та нарыг хүүхдийн хөгжил рүү чиглэж ажилладаг гэдгийг чинь ойлгохгүй байх шалтгаан юм болов уу гэж би харж байна?**

-Бидэнтэй ойр ажилладаг хүмүүс сайн ойлгодог. Ажил мэргэжлийн онцлог хаана ч яригддаг. Бид багийнхаа иргэдтэй их ойр ажилладаг. Тэдэнтэй энгийн хэллэгээр л ярьдаг.

**-Хувийн чанартай зүйл асууя. Өнгөрсөн хугацаанд та бүхэн Монголын тогтворгүй,**

байдаг. Манайх ашгийн бус байгууллага. Гэхдээ бид манай шаардлагад нийцсэн хэнтэй ч хамтарч ажиллахад бэлэн байдаг. Бидний хамгийн ойрын хамтрагчид бол төрийн бүхий л шатлалын байгууллагууд. Улс төрийн болон ашиг олох зорилгоор хамтарч ажиллах саналыг хүлээж авдаггүй.

**-Та байгууллагынхаа үйл ажиллагаа, зорилго, чиглэлийн талаар эцэст нь дүгнээд хэлэхгүй юу?**

-Нэгдүгээрт, хүүхдийг 0-5 нас хүртэл нь эрүүл мэнд, 6-12 нас хүртэл нь сурч боловсрох, 13-18 нас хүртэл нь амьдрах ухааны чадвар эзэмшүүлэхэд нь илүү анхаарах ёстой байдаг. Үүнийг бүрэн утгаар нь хийж чадвал хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж байгаа гэсэн үг. Хоёрдугаарт, хүмүүс хүүхдийнхээ материаллаг хэрэгцээг хангаснаа сайн аав, ээж гэж боддог. Гэтэл хүүхдийн хэрэгцээ бидний бодсоноос эсвэл бодоогүй байснаас ч бага хэмжээний зүйл байдаг. Өрх гэрийн халуун дулаан уур амьсгал

# АЖЛЫН 90 ХУВЬ НЬ НЬ ХАЛАМЖ РУУ ЧИГЛЭДЭГ

...Бидний үйл ажиллагааны чиглэл улс төр, хувийн ашиг сонирхлоос ангид байдаг. Манайх ашгийн бус байгууллага. Гэхдээ бид манай шаардлагад нийцсэн хэнтэй ч хамтарч ажиллахад бэлэн байдаг. Бидний хамгийн ойрын хамтрагчид бол төрийн бүхий л шатлалын байгууллагууд. Улс төрийн болон ашиг олох зорилгоор хамтарч ажиллах саналыг хүлээж авдаггүй...

элэг бүтэн амьдрах ёстой. Бид хүүхэд бүрийн амьдрал, хөгжлийн төлөө ажилладаг. Хүүхдийг анхаарахын тулд гэр бүл, эцэг, эх, өрх гэрийн эдийн засгийн чадавх хамааралтай байдаг. Иймд гэр бүлд чиглэсэн олон үйл ажиллагаа явуулсан. Жишээ нь, гэр оронгүйгээ шалтгаалж өрхийн гишүүд тал, тал тийшээ таран амьдрах тохиолдол олон байдаг. Энэ асуудлыг шийдэхийн тулд “Гэрээр бэлэг барья” төсөл хэрэгжүүлж, Орхон аймгийн 400 гаруй өрхийг орон гэртэй болгосон. 500 гаруй өрх амьдрах нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг болгож, байшин барих материалаар хангасан. Мөн эрүүл мэндийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хэд хэдэн өрхийн эмнэлгүүдийг байгуулах, хэрэгцээт тоног төхөөрөмж, арга зүйгээр хангах, хүүхдийн боловсролын асуудлыг дэмжих зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийг ч барьж байгуулсан нь олон. Усны асуудлыг шийдэхийн тулд гэр хороололд олон гүний худгийг бий болгосон. Мөн урлагаар дамжуулж, нийгэмшүүлэх зорилгоор хүүхдийн найрал дууны хамтлаг, зургийн дугуйлан, бусад хөгжүүлэх дугуйлан, клубуудыг хичээллүүлсэн. Хүүхдийн сэтгэлийн хямрал, гэмтлийг эмчлэх зорилгоор урлагийн боловсрол олгох эхэлсэн. Үүний үр дүнд хүүхдүүд бусдыг хайрлах, өөртөө итгэх, авьяас чадвараа нээж байна. Түүнээс гадна сургууль завсардан хүүхдүүдийг Албан бус боловсролоор дамжуулж, боловсрол олгох төслийг анх эхлүүлсэн. Энэ төсөл нь одоогийн “Албан бус, насан туршийн боловсрол төв”-ийг үүсгэн байгуулах суурийг тавьсан байдаг. Хүүхэд, гэр бүлийн асуудлыг хэзээ ч тусад нь авч үзэж болохгүй.

дамжуулан “Гэр бүлийн хүчирхийллэтэй тэмцэх тухай” хуулийг шинэчлэх шаардлагатай гэдгийг ойлгуулж, батлуулж чадсан. Мөн хүүхдийн оролцоог бий болгох зорилгоор олон удаа зөвлөгөөн, чуулган, нөлөөллийн ажил хийснээр төрийн бодлогод хүүхдийн оролцооны тухай асуудал туссан. Түүнээс гадна хүүхдийн тусламжийн 108 дугаарын утсыг “Дэлхийн зөн” анх санаачилсан. Ингэснээр хүүхдийг эрсдэлд өртөхөөс хамгаалах, шаардлагатай арга хэмжээ авах тогтолцоо бий болж, улмаар “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн суурийг тавьсан.

### Монгол хүний сэтгэхүйг өөрчлөх хэцүү

**-“Дэлхийн Зөн” ОУБ 1995 онд Монголд төлөөлөгчийн газраа нээсэн. Энэ үед Монголын эдийн засаг, нийгэм, хүүхэд, гэр бүл тэр чигтээ бөөн “асуудал” байсан шүү дээ?**

-Тийм ээ. Тухайн үед тэнэмэл хүүхэд, тэдний эрүүл мэнд, амь нас, боловсрол гээд шийдэх олон ажил байсан. Үүнийг шат дараалалтайгаар хийснээр дараа, дараагийнхаа төсөл, хөтөлбөр, хандлага, өөрчлөлт рүү чиглэж байсан. Жишээ нь, тухайн үед таваас доош насны хүүхэд хоол тэжээлийн дутаглал, өсөлт хоцрогдол, хүнд нөхцөл дэх хүүхэд, гудамжны тэнэмэл, хүчирхийлэлд өртсөн хүүхэд олон байсан. Үүнийг манай байгууллагаас хийсэн ажлууд цэгцэлсэн. Тухайлбал, 2000-аад оны үед боловсролын чиглэлээр бичиг үсэггүй, сургуулиас завсардсан хүүхдийг боловсролтой болгосон. Өрхийн амьжиргааг дээшлүүлэх, сургалт явуулах, ажлын байраа өөрсдөө бэлтгэх зэрэгт өрх гэрийг сургасан.

-Шууд хэлэхэд, арчаагүй хүний амьдрал дорой байдаг. Хүний сэтгэлгээ бүх зүйлийг бэлэнчлэх. Энэ сэтгэхүйг өөрчлөхмашхэцүү. Өөрчлөхийн тулд олон хүн хамтран, өөр хандлагаар ажиллах нь чухал.

**-Өөрчлөлтийг хаанаас эхлүүлэх нь зүйтэй вэ?**

-Гэр бүлээс. Нийгмийг бүрдүүлэгч анхан шатны нэгж нь гэр бүл. Гэр бүл ямар байхаас хүүхдийн хүмүүжил, цаашлаад улс орны хөгжил ямар байх шалтгаалдаг. Иймд гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор манай байгууллага мэдлэг, хандлагын сайжруулах чиглэлээр нөлөөллийн ажлуудыг явуулж байна. Ингэснээр гэр бүлийн үүрэг, хариуцлага нэмэгдэх юм.

**-Монгол хүүхэд учирч болох эрсдэл олон байна уу?**

-Ер нь хүүхдийн эрсдэл байсаар байгааг олон судалгаа, мэдээллээс харж болно. Өнгөрсөн жил Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсан. Олон жилийн дараа л хүүхдээ хамгаалах хууль нь илүү боловсронгуй болж байна шүү дээ. Хүүхдээ үл хайхрах, сонсохгүй, анхаарахагүй байх хүчирхийлэл манайд түгээмэл байдаг. Хүүхдийг хамгаалахад хүн бүрийн оролцоо чухал. Зөвхөн хүүхдийн хүчирхийллийн асуудлыг авч үзье. Хүүхдээ үл хайхрах, сонсохгүй, анхаарахгүй байх хүчирхийлэл манайд түгээмэл байдаг. Мөн монгол хүний сэтгэхүйд хүүхдээ зодож шийтгэснээрээ хүмүүжүүлж байна гэх уламжлалт хандлага байдаг. Энэ бол хүчирхийллийн бас нэг ноцтой хэлбэр юм. Манай монголчууд хүүхдийн хүчирхийллийг гэхээр аав, ээж нь архичин, салсан гэр бүлд илүү тохиолддог юм шиг ойлгоод байна. Магадгүй та ингэж бодож байгаа бол хүүхдээ үл хайхрах хүчирхийлэлд өртүүлж байгаа юм биш биз гэж өөрсдөө асуух хэрэгтэй.

**-Хүүхдийн хөгжил, хамгаалалд өрхийн эдийн засгийн чадавхи чухал биз?**

-Манайх хүүхдийн байгууллага. Тэгсэн хэрнээ яагаад насанд хүрэгчдэд хандаж үйл ажиллагаа явуулж байгаа юм бэ гэж олон хүн асуудаг. Бидний бүх ажлын гол бай нь хүүхэд. Өрхийн даван туулах чадавхи гэдэг нь эцэстээ хүүхдийн асуудал дээр л буудаг. Тухайн өрх гадна болон дотоод эрсдэлд бэлэн байх нь хүүхдээ хамгаалж буйн нэг илрэл юм. Жишээ нь, байгалийн гэнэтийн гамшиг ослын үед өрх гэр тэсч үлдэх нь гадаад нөхцөл, өрхийн эдийн засгаа хүчирхэгжүүлж, орлого, зарлагаа зөв хуваарилж, эрүүл мэнд, нийгмийн хэрэгцээгээ хангаж чаддаг

байна. Харин Дэлхийн Зөнгийн ажил бол 100 хувь сэтгэл, хандлага шаардсан ажил юм.

**-Та Дэлхийн Зөнтэй хэзээнээс холбогдсон бэ?**

-2010 оноос ажиллаж байна. Хамгийн доод шатны ажлаас ажлын гараагаа эхэлсэн. Анх “Дэлхийн Зөн”-ийн талаар ямар ч ойлголтгүй байсан. “Дэлхийн Зөн”-ийн хийж байгаа ажил бүр утга учиртай, үнэ цэнэтэй байсан. Ажлаараа дамжуулж

**хайхрамжгүй улс төрийн нөлөөллөөс яаж ангид байж чадав аа. Эсвэл би анзаарсангүй юу. Улсторчид сонгууль дөхөхөөр нийгэмд амжилттай яваа төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөр дээр хамтарч өөрсдийн нэр төрөө өсгөж байгаа харагддаг?**

-Бидний үйл ажиллагааны чиглэл улс төр, хувийн ашиг сонирхлоос ангид

тэдний номер нэг хэрэгцээ гэдгийг ойлгох хэрэгтэй. Хүүхдийнхээ төлөө бүхнийг хийж чаддаг иргэн, аав, ээж илүү олон байгаасай гэж хүсч байна. Гуравдугаарт, одоо бид өөрсөддөө, монголчууд монголчуудаа туслах, дэмжих цаг нь болсон. Хэн нэгэн гар харалгүйгээр өөрсдийнхөө болон өрөөл бусдыг туслах нь бидний улс орныхоо хөгжилд оруулж байгаа хувь нэмэр юм.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017/05/10
**Тендер шалгаруулалтын нэр:** Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасгийн засварын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** 2017-А016

[Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар] эрх бүхий тендерт оролцогчдоос [Буулгах ажил, хана хамар, хаалга, цонхны ажил мөн эмнэлэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендер]–ыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Багц-1 Нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасгийн засварын ажил

Багц-2 Нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасагт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь [50,000] төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас доошгүй байх.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** /Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй/
- **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** [Сүүлийн 2 жилийн /2015 он 2016 он/ санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан ирүүлэх шаардлагатай]. Сүүлийн нэг жил ашигтай ажилласан байх
- **Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 3 жилд ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /Гэрээ, ажил хүлээлцсэн актыг хавсаргах/
- **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:**

**Багц-1 Барилга хот байгуулалтын яамны:**

2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил,

Цутгамал болон угсармал төмөр бетон арагт бүтээцэн барилгын ажил (1- 5 давхар хүртэл),]

**Багц-2 Эрүүл мэндийн яамны:**

Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй байх

**Тендерийн хамт:**

Багц-1 Нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасгийн засварын ажил-1800,000 /Нэг сая найман зуун мянган төгрөг/

Багц-2 Нэгдсэн эмнэлэгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах тасагт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах-600,000 /Зургаан зуун мянган төгрөг/

Хүчинтэй байх хугацаа: Багц1 болон Багц2-ын хугацаа нь 2017он 08 сар 24 өдрийг дуустал

Тендерийг [2017 оны 06 дугаар сарын 12-ны 14:00 цаг]–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [2017 оны 6 дугаар сарын 12 ны ]-ны өдрийн, [14 цаг 30 минут] -д нээнэ.

**Дотоодны давуу эрх тооцох эсэх.Тооцохгүй**

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Утас:96510404, 70518123 Мэргэжилтэн Э.Уранчимэг 99037899)

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[Сүхбаатар аймаг Орон нутгийн өмчийн газар-Аймгийн нутгийн удирдлагын ордон 3 давхарт 306 тоот өрөө Мэргэжилтэн Э.Уранчимэг 99037899, 70510020)]**

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Налайх дүүргийн Соёл ордны таазыг засварлах ажлынхяналтын төсвийг боловсруулах, засварын ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал авах баримт бичигийг бичгээр хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 100.000 /нэг зуун мянга/ төгрөгөөр худалдан авч болно.

Төлбөрийг Төрийн сан банк- 100200455009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Үнийн саналыг 2017 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минут-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2017 оны 05 дугээр сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

**Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо, Хуульчдын гудамж, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын байр Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788 www.tender.gov.mn, www.nalaikh-tender.mn**

# ЗАВСАРЛАГА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



# Эх орны дайны ялалтын 72 жилийн ойг ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭЛЭЭ











Б.СУМЪЯА

Орос улс Аугаа их Эх орны ялалтын 72 жилийн ойн баяраа ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Тэртээх 1945 оны тавдугаар сарын 9-нд Дэлхийн II дайныг өдөөгч Гитлерийн Берлин хотод үг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зурснаар энэ өдрийг албан ёсоор Зөвлөлтийн ард түмний ялалтын баяр болгон тэмдэглэх болсон юм. Энэ өдөр бол ганц Зөвлөлт ч гэлтгүй Дэлхийн II дайнд зовж, зүдэрсэн бүхий л ард түмний ялалтын баяр билээ. Аугаа эх орны дайны ялалтын 72 жилийн ойд зориулсан цэргийн сүрт жагсаал Оросын 28 хотод болж, нийтдээ 90 мянган цэргийн алба хаагч оролцлоо. Гэхдээ хамгийн олон хүн, техник хэрэгсэл оролцсон сүрт жагсаал нь нийслэл Москва хотын Улаан талбайд болсон юм. Тус цэргийн сүрт жагсаалд 10000 цэргийн алба хаагч, 114 нэгж цэргийн техник хэрэгсэл, 72 нисэх онгоц оролцсон юм. Парадыг ОХУ-ын Батлан хамгаалахын сайд Армийн генерал, ОХУ-ын баатар Сергей Шойгу удирдаж, Ерөнхийлөгч В.Путинд илтгэл өглөө. Улмаар ялалтын баярын парадыг нээж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин үг хэлэв.

Тэрбээр "ОХУ-ын нөхөд дайчид цэрэг дайчид, ахмад дайчид генерал, адмиралууд аа та бүхэнд агуу эх орны баярын мэнд хүргэе. Нацистын Германыг ялахад өөрсдийн агуу их зориг гаргасан баярын өдрийг бид өнөөдөр эргэн дурсаж байна. Энэ өдөр маш олон хүний амийг хохироосон аюулт хүчийг зөвхөн өөрсдийн ард түмэн бус бусад ард түмний амийг хамгаалахын тулд байлдаж хамгаалахын тулд байсан. Зөвлөлтийн ард түмэнд хамгийн том хохирол ирсэн. Тэр хохирлыг давж өөрсдийн эх орон болон газар нутгийг чөлөөлж, нацизмын зэрлэг хүчийг дарсан хүмүүс бол бидний өвөг дээдэс, маршал, байлдагчид, партизанууд юм. Тэд төсөөлшгүй хүнд үеийг давж энэ ялалтыг авчирсан. Тэдний ар талд үүрэг гүйцэтгэж байсан үйлдвэрийн ажилчид, эмнэлгийн сувилагч, эмч нар энэхүү дайнд ялахын тулд бүхнээ зориулж байсан. Өнөөдөр бид энд цуглаж тэдгээр өвөг дээдэс, эр нөхөр, үр хүүхдийнхээ дурсгалыг хүндэтгэж тэдний бүтээсэн үйл хэрэгт зориулж нэг минутын хүндэтгэл илэрхийлэхийг хүсч байна. Эрхэм нөхөд өө, тавдугаар сарын 9-ний баярыг манай улсын өнцөг булан бүрт тэмдэглэж байгаа. Зөвхөн бид баярлаагүй.

Тэдний дурсгалыг хүндэтгэж байна. Ахмад дайчиддаа хандаж бид та бүхний итгэлийг алдахгүй. Өнөөдрийн дайчид эх орныхоо аюулгүй байдлыг хамгаалах болно" гэлээ. ОХУ-ийн баяраа ийн нүсэр тэмдэглэсэн бол манайд энэ өдөр ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар, ЗХУ -ын Эх орны их дайны цуут жанжин, ЗХУ-ын маршал Г.К.Жуковын хөшөөнд болон Зайсан дахь Зөвлөлтийн дайчдын хөшөөнд ОХУ-аас Монголд суугаа Элчин сайд И.К.Азизов болон иргэд хүндэтгэл үзүүлж, цэцэг өргөсөн юм. Хүн төрөлхтөний түүхэнд гай гамшиг учруулсан II дайны нэг том хэсэг нь Зөвлөлтийн ард түмний Аугаа их эх орны дайн билээ. Уг дайн ОХУ болон Монгол Улсын түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээсэн, хоёр орны ард түмний найрамдлын нэгэн алтан хуудас болон мөнхөрсөн.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН









Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 9
Шөнө -4

Нөгөөдөр
Өдөр 13
Шөнө -5

## Өдрийн зурхай

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 05.21-20.17
**Үс засуулбал:** Өлзийтэй сайн



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой.*

МЭДЭЭЛЭЛ

## В.Путин даргаа эргэж очжээ



ХУ-ын арми нацистын Германы армийг бут цохиж дэлхийд энх тайван тогтоосон эл өдөр Оросын төдийгүй, тэдний холбоотнууд, дэлхийн бусад улсад маш онцгой өдөр юм. Тэгвэл эл баярыг угтан ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин 90 насыг зооглосон ЗХУ-ын тагнуулын албанд өөрийнх нь дарга байсан Лазарь Матвеевд гэнэтийн бэлэг барьжээ. Тэрбээр бугуйн цаг болон 1927 оны "Правда" сонины дугаарыг бэлэглэн мөн оргилуун дарс буудуулсан байна.


УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗУУ" ЭМНЭЛЭГ

УЛАМЖЛАЛТ ЭМЧИЛГЭЭНИЙ ГАН ЗҮҮ НЭГДСЭН ЭМНЭЛЭГ



Манай эмнэлэг дотор 5 цул, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван засалын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танд:
- Ган болон мөнгөн зүү, цахилгаан зүү
- Ханүүр, сам соруул
- Шарлага
- Бумба төөнө засал
- Халуун чулуу, давсан халуун жин засал
- Эмчилгээний цэгэн бариа
- Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ

Холбогдох утас: 9999-5584
9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/